

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

Судар бичгийн хүрээлэнгийн 100 жил,
Шинжлэх ухааны академийн 60 жилийн ойд зориулав.

Шүүмж өгсөн: Академич Х. Намсрай

Академич Г. Чулуунбаатар

ОРЧЛОНГИЙН НУУЦЫГ ТАЙЛАХУЙ

(Компаратив философийн судалгаа)

Редактор: Философийн доктор Ш. Ганхуяг

УЛААНБААТАР, 2020

ОРЧЛОНГИЙН НУУЦЫГ ТАЙЛАХУЙ

Орчлонгийн тогтвортой зүй тогтлын философийн үндэслэл

(Philosophical interpretation of stable laws of the Universe)

Түгээмэл удиртгал (Universal introduction)

*Нэгдүгээр бүлэг. Оюун санааны гол цөм нь шинжлэх ухааны мэдлэг болдог зүй тогтол
(General regularity of scientific knowledge becoming the main core of the soul)*

Нэг. Философи шинжлэх ухаанч болох арга зам (Ways and methods of formation of scientific philosophy). Онтологийн “эргэлт” (ontological "turn")

Хоёр. Монголын буддын философийн ахуй ёс (Ontology of the philosophy of Mongolian Buddhism)

Гурав. Орчлонгийн шүтэн барилдах журмын танин мэдэх ёсны үндэслэл (The Epistemological Foundation for a Harmonized Universe Order)

Дөрөв. Орчлонгийн жам ёсны хөгжилд шинжлэх ухаан, технологийн үүрэг (The role of science and technology in the natural development of the Universe)

Хоёрдугаар бүлэг. Орчлонгийн тогтвортой зүй тогтлын ерөнхий ба тусгай онцгой шинж (General and special in the implementation of the laws of the Universe)

Нэг. Орчлонгийн жам ёсны бодит байдал, орон ба хугацааны мэдэгдэхүүний билиг (Phenomenology of objective reality, space and time)

Хоёр. Квант механикийн философийн асуудлыг харьцуулан шинжлэхүй

Гурав. Квант онол ба мадхьямака хэмээх төв замын философи (Quantum theory and philosophy of the middle path Madhyamika)

Дөрөв. Квант физик ба Йогочара хэмээх сэтгэл төдийтний философи (Quantum physics and the Yogachara philosophy)

Гуравдугаар бүлэг. Орчлон ертөнцийн түгээмэл зүй тогтлыг бүхэлд нь тайлбарлах оролдлого (Interpretation in the unity of the General laws of the Universe)

Нэг. Бөөмсийн физик ба одон физик, философийн шүтэн барилдахуй (Interdependence of particle physics, astrophysics and cosmology)

Хоёр. Их нэгдлийн онолын философийн асуудал (Philosophical problems of the Grand Unified Theory (GUT))

Гурав. Хэт тэгш хэмийн онолын философийн асуудал (Philosophical problems of the supersymmetry theory (SUSY))

Дөрөвдүгээр бүлэг. Орчлонгийн нэн орчин үеийн бодисын зүйн философийн асуудал (Philosophical problems of the super-modern physics of the Universe)

Нэг. Нэгэн цогц чанарын тайлал зүйн мэдэгдэхүүний билиг (Phenomenology of the singularity of the Universe)

Хоёр. Хэт чавхдасны онолын мэдэгдэхүүний билгийн тайлал (Phenomenological interpretation of the superstring theory of the Universe)

Гурав. Орчлон дахь эмхгүй ба эмх журмын жам ёсны шүтэн барилдахуй (The natural interdependence of order and chaos)

Дөрөв. Хар нүхний мэдэгдэхүүний билиг (Phenomenology of a black hole in the Universe)

Тавдугаар бүлэг. Сав шимийн ертөнцийн үндсэн зүй тогтлын тайлал (Interpretation of the general laws of the natural world life of the Universe)

Нэг. Байгалийн хувьслын үндсэн зүй тогтол ба онол, шинэ үзэл санаанууд (Basic regularity and theory of the evolutionary development of nature and new ideas)

Хоёр. Экологийн хямралын философийн асуудал (The philosophical reflections and public discourses on recurrent human concerns, such as ecology)

Гурав. Байгаль, хүн ба техник, технологи шүтэн барилдахуйн философийн асуудал (Philosophical problems of the interdependence of nature, man and technology)

Дөрөв. Биотехнологийн хөгжлийн философийн асуудлууд (Philosophical problems of biotechnology development)

Тав. Хиймэл оюун ухаан, тоон технологийн философийн асуудал (Philosophical problems of artificial intelligence)

Зургадугаар бүлэг. Хүмүүнлэгийн ертөнцийн үндсэн зүй тогтлыг тайлбарлах шинэ хандлага (A new trend in the interpretation of the General laws of the humanitarian world)

Нэг. Хүмүүнлэгийн ухааны тайлал зүйн мэдэгдэхүүний билиг (Hermeneutical phenomenology of the Humanities)

Хоёр. Хэл, сэтгэл ба ухаарлын шүтэн барилдахуйн тайлбар (Interpretation of the laws of harmony of language, spirit and mind)

Гурав. Оюун санаан дахь ба соёл, урлагийн үнэлэмж (Values of language, culture and art in a spiritual experience)

Дөрөв. Урлаг болоод хүмүүнлэг уламжлалд үндэслэн үнэнийг эрэхүй (The search for truth through art and humanistic traditions)

Тав. Орчлонгийн зохист аялгууны суурь онтологийн тайлал (Interpretation of the fundamental ontology of the harmony of the Universe)

Зургаа. Хөгжмийн сэтгэлгээний ахуй ёсны үндэслэгээ (The ontological Foundation of the musical reasoning)

Түгээмэл удиртгал (Universal introduction)

Асуудлын тулгамдсан байдал. Шинжлэх ухааны судалгааны бүрдэл хэсэг, ялангуяа, тусгай хүрээнээс халин гарч түгээмэл зүй тогтолтой холбогдох талыг нь философийн байр сууринаас судлах нь шинжлэх ухаанч философийн хийх ажил билээ. Орчин үеийн шинжлэх ухааны зорилго ба үйл ажиллагаатай холбогдох метафизик, космологи, танин мэдэхүй, тайлал зүйн асуудал болон тодорхой шинжлэх ухаануудын дэвшүүлэн гаргаж байгаа Орчлонгийн хамгийн түгээмэл зүй тогтлын тухай онол, үзэл баримтлалуудын философийн үндэслэлийг шинжлэх нь тулгамдсан асуудал болоод байна.

“Орчлон” бол шинжлэх ухааны төдийгүй философи, хүмүүнлэгийн ухааны нарийн түвэгтэй ухагдахуун бөгөөд түүний агуулгад одод гараг, газар дэлхий, түмэн бодис, хүн нийгэм хийгээд байгаль ертөнцийн жам ёс, хүмүүний амьдрал үйл ажиллагааны оюун сэтгэхүй, ёс зүй, эдийн засаг, сэтгэл зүй болон социаль салбаруудын түгээмэл мэдлэг ч багтдаг. Энэ бүх тал, салбар нь өөр өөрсдийн үйлдлийн хүрээнд тохирсон өвөрмөц онцгой шинж чанартай байх хэдий ч Орчлон хэмээх нэг бүхэл айн бүрдэл хэсэг болохын хувьд хамгийн ерөнхий үндсэн зүй тогтол болох шүтэн барилдахуй, эцэс төгсгөлгүй эргэлдэн орчихуйтай холбоотой. Философи бодит байдлын мэдэгдэхүүний ерөнхий тодорхойлолтыг Орчлонгийн бүх юм, үзэгдлийн чинадын энэхүү түгээмэл зүй тогтлын шаардлагаас ургуулан эрэн сурвалжилж, эргэцүүлэн тайлахыг оролддог. Орчлонгийн юм, үзэгдэл ба хүмүүний үйлдэл бие биетэйгээ болон тухайн нийгмийн үнэт зүйлс, үнэлэмжийн хэм хэмжээтэй шүтэлцэх жам ёсны зохицлын үзэл санаа агуулагдаж байдаг. Бидний судалгааны хандлага энэ бүх тал, холбогдох заагийг тооцон шинжилж, бүх оршигчийн шүтэн барилдахуйн ерөнхий зүй тогтлыг ойлгож, тайлбарлахуйг онол, арга зүй, эргэцүүллийн өндөр түвшинд хангаж өгөхөд оршино.

Орчлонгийн нууцад алхам алхмаар гүнзгийрэн нэвтэрч, шинжлэх ухаан хараахан тайлж амжаагүй байгаа баримт, үйл явц, зүй тогтлын мэдэгдэхүүний урьдач утгыг ойлгох, онолын хийсвэр загвар бүтээх, технологийн өндөр хурдтай хөгжлийг ашиглан зөв утган харж чадсанаар өөрчлөлт хөгжлийн тогтвортой төлөвийг философийн хувьд үндэслэх

боломж бүрдэнэ. Хүн төрөлхтний өмнө тулгарч буй шийдвэрлэх асуудалтай уялдуулан олон соёлын хүрээнд эртний болон эдүгээгийн сэтгэгчдийн философидох янз бүрийн хэлбэрийг харьцуулан судлаж баймаажин философийг шинжлэх ухаанч болгох зорилтыг дэлхийн философичдын сүүлчийн Конгресс (2018) дэвшүүлсэн билээ. Монголчуудын оюун санааны түүхэн уламжлалд газар дэлхий, одот тэнгэр, огторгуй болон байгаль ертөнцийг "савын ертөнц" хэмээн түүнд шүтэн оршигч амьтны төрлийг "шимийн ертөнц" хэмээн үздэг байв. Монголын буддын философийн уламжлал ёсоор шимийн амьтан нь "тэнгэр, асури, хүн, адгуус, бирид, там" хэмээсэн зургаан зүйл буй. Үйлийн үрийн хуулиар зовлонд унаж нисваанисын эрхэнд автаж, энэ зургаан төрөлд дахин дахин төрж, зовлонгийн шалтгаанаас ангижирч чадалгүй, эцэс төгсгөлгүй эргэлдэх төрх байдлыг "орчлон" хэмээмүй. Монголын шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хурал “Хандлагаа өөрчилъе” гэдэг түүхэн шийдвэр гаргалаа. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхдээ шинжлэх ухаанч философийн тухай, орчин үеийн ертөнцөд түүний эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, зорилгын тухай шүүмжлэлт эргэцүүлэл, мэтгэлцээнд онцгой анхаарах ёстой болж байна. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд философийн дискурс буюу эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн, нийгмийн болон байгалийн шинжлэлийн салбар ухаанууд, эдийн засаг, нийгэм, улс төр, шашны хүрээ хийгээд янз бүрийн соёл, уламжлалын үйл ажиллагааны хэлбэрүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах зам хамгийн үр дүнтэй юм. Философийн эргэцүүллийн төвд “хүн”-ийг тавьж, улмаар хүнд тулгамдсан асуудлыг Орчлонгийн зүй тогтлоос олж тогтоох, шийдвэрлэх үүрэг, зорилтууд гэвэл:

- орчин үеийн ертөнцөд философийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, зорилгын тухай шүүмжлэлт эргэцүүлэл (critical reflections)

- олон соёлын хүрээнд эртний болон эдүгээгийн сэтгэгчдийн философидох янз бүрийн хэлбэрийг (diverse forms of philosophizing) бүрэн хамрахын тулд философийн судалгааг даяаршлах

- тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд философийн эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн, нийгмийн болон байгалийн шинжлэлийн салбар ухаанууд, эдийн засаг, нийгэм, улс төр, шашны хүрээ хийгээд янз бүрийн соёл, уламжлалын (diverse cultures and traditions) үйл ажиллагааны хэлбэрүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах (fruitful interactions) арга зам:

• экологи, шударга ёс ба энх тайвны үйлсэд гарч буй хямралт асуудлаар олон нийтийн мэтгэлцээн (public discourses) хийж байх явдал болно¹.

1. **Сэдвийн шинжлэх ухаанчаар боловсруулагдсан байдал.** Өнгөрсөн зуунд гарсан шинжлэх ухааны нээлтүүд, ялангуяа Харьцангуйн онол ба квант механикийн үзэгдлүүдийг европ төвт уламжлалт философи бүрэн зөв тайлж чадахгүй мухардалд орсон билээ. Орчлонд яагаад энэ олон янзын юмс оршиж, тэднийг нарийн чанд хуулиуд удирдаж байдаг вэ? гэдэг асуулт одоохондоо хариу байхгүй байгаа философийн чухал асуудлын нэг юм. Квант механик, таталцал космологийн салбарын судалгаагаар мэргэшсэн Шон Майкл Кэрролл(Sean Michael Carroll)-ын бичсэнээр “манайд огт өөр биш чухам ийм хуулиуд үйлчилдгийг орчин үеийн физик тайлбарлаж чаддаггүй”² тул философид хандах болдог, гэтэл философи нь шинжлэх ухаанч биш байдаг ажээ. Америкийн астрономч, од гараг судлаач, космологич, астрофизикч, астробиологч, зохиолч, шинжлэх ухааны тайлбарлагч Карл Саган (/ˈseɪɡən/) “(байгаа бүхэн, эсвэл байсан бүхэн, эсвэл хэзээ нэгэн цагт бий болох бүхэн) давтагдан гарч, амьдралд хязгааргүй олон боловсордог” гэж тодорхойлсон. Роботтехник, хиймэл оюун ухаан ба технологийн нөлөөллийн тухай бүтээлүүдээрээ нэрд гарсан Ханс Моравец олон ертөнцийн квант тайлбарын тухай хэлэхдээ “...хэрэв бид амьд л байгаа юм бол Орчлонг ямар нэгэн хэлбэрээр ажиглаж, дагахгүй байх аргагүй”³ гэж тайлбарласан юм.

Орчлонгийн жам ёсны тэдгээр хачирхалтай зүй тогтлын утга учрыг байнга орчин, урван өөрчлөгдөгч энтропи чанарыг хүлээн зөвшөөрдөг дорно дахины философи хүмүүнлэг үзэл, нигүүлсэх сэтгэл, хамаг амьтны тусын тулд өөрийгөө золиослох сайн буянт үйл зэрэгтэй холбон тайлбарладаг нь анхнаасаа илүү шинжлэх ухаанч байсан. Тийм учраас философийн онтологид эргэлт, танин мэдэхүйд хувьсгал хийхийн тулд орчин үеийн шинжлэх ухааны философи ба монголын буддын философийн дэвшилт уламжлалыг харьцуулан судлах нь хамгийн чухал ач холбогдолтой юм.

¹ The XXIV World Congress will be held in Beijing, China, from August 13 to August 20, 2018

² SM Carroll, [Is cosmic speed-up due to new gravitational physics?](#) V Duvvuri, M Trodden, MS Turner - Physical Review D, 2004. P. 4.

³ Moravec, Hans (April 2004). "[Robot Predictions Evolution](#)". Retrieved 2006-06-23

Орчлон (англиар “universe” латинаар “universes”) гэдэг нь бүх орон ба хугацаа бөгөөд од, гараг, галактик болон матери ба энергийн бусад бүх хэлбэрийг хамран тодорхойлж байдаг ойлголт билээ. Энэ ойлголтонд манай дэлхий байгаль ертөнц ба хүн төрөлхтөнтэйгөө хамт багтдаг. "Орчлон" хэмээх монгол ойлголтын язгуур нь "орч-" (орчих) бөгөөд эртнээс эдүгээ хүртэл идэвхтэй хэрэглэгдэж байгаа монгол үг болно. "Монголын нууц товчоон" тэргүүтэй монгол бичгийн хэлний дурсгалд энэ нэр томъёо түгээмэл тохиолддог бөгөөд утга нь "тойрох, эргэх"-тэй ойролцоо боловч нарийн ялгамж ажиглагддаг. "Тойрох" хэмээвээс "хүрээлэх"-тэй адил утгатай агаад үргэлжийн хөдөлгөөнд орших эсэх нь тод бус юм. Харин "орчих" хэмээвээс орон, хугацааны дотор үл тасрах өөрчлөлт хөдөлгөөнд оршихыг тухайлан заадаг. Үүнийг лавшруулан ухахын тулд "Хорин наймт тайлбар толь"-д үзвээс, "Байгаль ертөнцийн орон цаг ба хамаг юм нь таван махбодын чанар хийгээд шүтэн барилдсан арван хоёр гишүүний эрхээр болж, агшин зуур урван хөрвөн хорогдон эвдэрсээр боловч орд (оронд) ор дараалан бүтэжирэхүй нь эргэн тойрон улирч (хувьсаж), үүрд мохох зогсохын эцэсгүйн тулд тийнхүү орчлон хэмээмүй" хэмээн бичсэнийг үндэс болгон баримтлав. Энэ олон талт, нийлмэл, олон хэмжээст судлагдахуун Орчлон ертөнцийн бүх өнцөг, тал хэсгүүдэд нэвчин шингэсэн төдийгүй газар сайгүй оршин хүмүүний ахуйг бүрэн дүүрэн хамарсан тул түүнийг судлах шинэ феномэнологи, шинэ космологи хэрэгтэй болж, тэднийг орчин үеийн шинжлэх ухаануудын онолын ололт, дорнын философийн тайлал зүй, мэдэгдэхүүний билиг хоёрын компаратив судалгаагаар бүтээх ёстой болж байна.

Нэг талаас, бүхнийг хамарсан тогтолцоот үндэслэлүүдийг нарийн шинжилж зүй тогтлыг нээх, нөгөө талаас ямар нэгэн зүйлийг шүүмжлэх нь философийн салшгүй бүрдэл мөний тул бие биенийгээ нөхцөлдүүлэн нэмж дүүргэж байдаг. Энэ утгаар олон шинжлэх ухааны заагт тэдний оролцоотой тайлбарлах, алсыг харах зорилгын үүднээс тогтвортой хөгжлийн оюун санааны үндсийг тодорхойлоход философи нь арга зүйн төдийгүй сэтгэлгээний чадварын ач холбогдолтой юм. Алив мэдлэгийг бүрэн дүүрэн боловсруулах төгсгөлийн үе шат болох шүүмжлэлт сэтгэлгээг бүтээлч сэтгэлгээгээр үндэслэж өгөх зарчим арга зүйн суурь уламжлалд харшлахгүй. Шүүмжлэлт сэтгэлгээ нь онтологийн хил хязгаараас цаагуур оршдог шинжлэх ухааны болон философи, хүмүүнлэгийн ухааны шинэ төсөөллүүдийн хам шүтэлцээг онтологид нийлүүлэх зорилгоор уламжлалыг шинээр хянан засварлахад туслана. Шүүмжлэлт сэтгэлгээний асуудал дэвшүүлдэг талбар нь тайлбарлах

судалгаа бүхэнд философийн хуучин байр суурь, философийн мэдлэгийн шинэ эрэлт хоёрын мөргөлдөөний хэлбэр болж байдаг онцлогтой.

Философчид метафизикээс авхуулаад ёс зүй хүртэл юм бүхнийг шүүн хэлэлцэж, тайлбарлахыг оролддог, ингэх ч эрхтэй байдаг тул оршихуйн үндсэн асуудлуудын заримынх нь нууцыг тайлан гаргах чадвартай. Гэсэн хэдий ч манай ойлгохуйн чинад үлддэг асуудлууд ч бас байдаг болохыг мартаж болохгүй юм. Улс түмэн бүхний хүмүүнлэг уламжлал, сэтгэлгэний өв соёлыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт амжилттай шүтэн барилдуулж чадсан ирээдүйн оюун мандлын ухаан л өөрийн танин мэдэхүйн хүрээнд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, загварыг оруулж бүрэн боловсруулахад тус болох болов уу.

Оршихуйн үндэс нь бодис, эсвэл оюун санаа байх ёстой гэж үздэг өрнөдийн монист философийн онтологи мухардалд орж, түүнээсээ гарахын тулд хэд хэдэн удаа онолын эргэлт, хувьсгал хийж байсан билээ. Үүний шалтгаан нь онолын физикт гүнзгий хямрал үүсгэж байгаа гол сөргөлдөөн болох Эйнштейний харьцангуйн ерөнхий онол ба оронгийн квант онол хоёрын хоорондох эвлэршгүй зөрчил байв. Эйнштейний ХЕО сонгодог онол болохын хувьд эргэлдэж буй хар нүх, материйн биет нягтрал эцэс төгсгөлгүй байх сингуляр чанар ба орон, хугацааны дотоод муруйлтыг хүлээн зөвшөөрөхөд зайлшгүй хүргэдэг. Энэ нь философийн хэлээр, нэгд, орон, хугацааны эцэс төгсгөлгүйн цэг болох сингуляр чанарт орон ба хугацааны сонгодог ойлголт өөрөө бүрэн төгс алга болж буйг, хоёрт, миллимикроны хэмжээсэнд матери өөрөө эцэс төгсгөлгүй хэмжээ болохыг, гуравт, барионик матери барионий эсрэг матери болж бүрэн алга болж буйг харуулж өгсөн. Сингуляр чанарын асуудлыг шийдэх нь дан ганц таталцлын квант онолыг бүтээхээр хязгаарлагдахгүй бөгөөд бүх ертөнцийн бүтцэд зөвхөн манай Орчлон ганцаар байдаг гэж ойлгохоос цааш алхаж, огт оргүйн чинад гарах нь зайлшгүй болохыг шаардах болов. Эгэл бөөмсийн болон астрофизик, космологид шугаман бус өөрчлөлтийн зарчим болон хуулиудад үндэслэн хийгдсэн агуу их ололт, нээлтүүд, сингуляр чанар, хэт чавхдасны онол, тэгш хэм, фрактал геометр ба эмхгүй (хаос) огторгуйн үзэлд тохирох Орчлон шүтэн барилдаж оршдогийн чинад утга, ач холбогдлыг философийн үүднээс тайлах болно.

Үүнд үндэслэн, бид өрнийн сонгодог философийн дутагдлыг даван гарч ирсэн Гадамэрийн философийн тайлал зүйн онол, хүмүүний оршихуйн дотоод тогтворгүй чанарын учир зүйг олж, онтологийг шинэчлэсэн Хайдэггерийн суурь үндэслэлүүд ба Хабэрмасын харилцан үйлдэхүйн үндсэн зарчмуудыг харьцуулан ашиглаж, цааш нэг

алхахыг хичээв. Чингэж гаргасан харьцангуй философи Орчлонгийн эмх журамгүй өөрчлөлтөт орчихуйг тогтворжуулахад хэт тэгш хэмийн байнга эргэн сэргэж байх зүй тогтлын үүрэг, хүчин зүйлийг нээн харуулах хамгийн тохиромжтой онол чойр мөн гэж үздэг эрдэмтэдтэй санал нэг байна⁴.

Нөгөө талаас, монголын уламжлалт сэтгэлгээний тайлал зүй, мэдэгдэхүүний билгийн ерөнхий үзэл санаа, буддын философийн хүмүүнлэг онол, арга зүйг ашиглах боломж бас байна. Энэ хоёр хандлагыг харьцуулан судлаж шинжлэх ухаанч философийн шинэ парадигмыг боловсруулах нь үр ашигтай шийдлүүдийн нэг байх болно.

Шинжлэх ухаан, технологийн дэвшил, хувь хүний төгөлдөршил ба байгаль нийгмийн харилцан үйлчлэлтэй нягт холбоотойгоор Орчлонгийн тухай ерөнхий ойлголт өөрчлөгдөн агуулга нь өргөжин тэлж байгааг анхаарахгүй байх аргагүй болжээ. Урагш түрүүлэгч ухамсрыг, нийгмийн ахуйгаас хоцорч дагах биш харин түүнээс түрүүлж урагшилсан хамтын оюун санааны дэвшлийг шинжлэх ухаанч философийн тусламжтайгаар төлөвшүүлэх явдал ухаан ба оюун шүтэлцсэн хүрээ, тоон технологид суурилсан оюун мандлыг цогцлон бүтээх замд хэрэгжих учиртай. Гэтэл өнөөдрийн өрнийн философийн албан ёсны тогтолцоо олон зуун дамжин амьдрах ухааны хуримтлуулсан мэдлэг, туршлага ба оюун билиг бүхнийг хоцрогдсон, хэрэггүй мухар сүсэг мэт үзэж, хэт объективчлогдсон шинжлэх ухааны мэдлэгийг цээжлүүлэх үзэл сурталжсан хандлагаасаа салж чадахгүй явна.

Судалгааны онолын үндэслэл, үзэл баримтлал ба арга зүй. Дорно өрнийн философийн эш онолын дэвшилтэт ололтыг шүтэн барилдуулж, давуу талыг хөгжүүлэн сул талыг орхин судлах компаратив судалгааны хүрээнд Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтлын тулгамдсан асуудлыг тогтвортой хөгжлийн зорилгод чиглүүлэн судлахын тулд монголын уламжлалт философийн тайлал зүй, мэдэгдэхүүний билгийн ерөнхий онолыг шинжлэх ухааны хийгээд хүмүүнлэгийн судалгааны арга зүй болгон хэрэглэхийг оролдов. Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Зава Дамдин гавж, С. Шагж гавж, дооромбо Ц. Гэлэгжамц нар болон академич Ч. Жүгдэр, Г. Лувсанцэрэн, доктор (Ph.D) Г. Лхагвасүрэн, Т. Булган нарын бусад эрдэмтдийн дэвшүүлсэн үндэслэлүүдийг компаратив арга зүйн эш

⁴ Fehér, M., Kiss, O., & Ropolyi, L., *Hermeneutics and Science* (Berlin/Heidelberg: Springer, 1999), p. 216

сурвалж болгон ашиглав⁵. Эдгээр эрдэмтэд “phenomen” гэдэг ойлголтыг “Мэргэд гарахын орон хэмээх тогтоосон даяг”-т тайлбарласныг үндэс болгон “мэдэгдэхүүн” хэмээн хэрэглэж, феноменологийг мэдэгдэхүүний билиг гэж үздэг монголын философичид болох Агваанбалдан, Агваанхайдав, Агваандандар, Занабазар нарын онол, арга зүйн буддист уламжлалыг үргэлжлүүлсэн юм. Манай нэрт философич З. Агваанбалдан “мэдэгдэхүүн нь хоёр үнэний ялгалын суурь мөн бөлгөө. Түүнийг хоёр үнэнээр ялгах нь буй бөгөөд Орчлонд орох, эгэхээс хамаарваас тэр хоёроос олон хэрэггүй, тэр хоёрын аль нэг үгүй бөгөөс үл хураагдахын учир мэдэгдэхүүн янагуух хийгээд үнэмлэхүй үнэн үүнээ барагдмуй”⁶ гэж сургажээ. Зава Дамдин багш “үзэгдэл нь өөрийн бэлгэ чанар ба нэрийдэл нь дуу, утга болой”⁷ хэмээчихүй. “Мэдэгдэхүүн”-ийг “үзэгдэл”-тэй хольж хугтахын гай, “түйтгэр”-ийг арилгах арга зүйг “Алинаа зорьсноор мэдэгдэхүүний түйтгэр тийн арилах зорилгыг үнэмлэхүй үнэн хэмээмүй. Алинаа зорьсноор хотлоос нисванис төрөх зорилгыг янагуух үнэн хэмээх бөлгөө”⁸ хэмээн үнэн ба аргын харилцаанд тодорхойлжээ. Монголын уламжлалт натур философи ба буддын ухааны өв өөрийн харьцангуй онтологи ба танин мэдэхүйн шүүмжлэгч байр сууриараа мэдэгдэхүүний билиг нь орчин үеийн шинжлэх ухаанч философи, бүх нийтийг тэгш хамарсан боловсрол, амьдрах ухааны үзэл баримтлалд нэн ойр бөгөөд ухаарлын чинад дахь оюун билгийн гүн увдисын бясалгал ба онтологийн шүүмжлэлт үзэл санаа болох бүлгээ. Энэ ач холбогдлыг тодорхойлж, академич Х. Намсрай буддын философи нь “...зөвхөн хувь хүн, хүмүүн төрөлхтөн, амьд ертөнцийн мөн чанарт хүрээд зогсохгүй биднийг хүрээлэн буй бүх хорвоо ертөнцийн нууцыг тайлжээ”⁹ гэж дүгнэсэн байна. Үүнийг ашиглан иргэншлийн хөгжлийн орчин үеийн загварыг философийн тайлал зүйн мэдэгдэхүүний билиг, үйлийн квант онолын үүднээс өөрчлөх цаг нэгэнт болжээ. Энэ хэрэгцээ, шаардлага одоохондоо тэргүүлэх байр сууринд гарч ирээгүй байгаа

⁵ Жүгдэр Ч. З. Агваанбалдангийн гүн ухааны үзэл. УБ., 2017, Булган Т. Буддын философийн дэвтэр. УБ., 2010, Лхагвасүрэн Г. Сэтгэл төдийтний гүн ухаан. УБ., 2018, Монголын буддын судлалын орчин үеийн асуудал. УБ., 2015

⁶ Агваанбалдан З. Хаврын охин тэнгэрийн дуулал нэрт дөрвөн тогтсон тааллын ёсны янагуух, үнэмлэхүйн утгыг номлосон сайн номлол оршвой. УБ., 2017. Х. 96

⁷ Зава Дамдин. Түүвэр зохиол (эх бичгийн эмхтгэл). УБ., 2012. Х. 119

⁸ Агваанбалдан З. Хаврын охин тэнгэрийн..., Х. 99

⁹ Намсрай Х. Бурхан багшийн сургаал ба Монгол орон. УБ., 2020 // <https://www.ac.mn/c/r?content=1086609>

ч эрдэмтдийн хүрээнд ухамсарлагдаж, тогтвортой ирээдүйд шилжих үед заавал харгалзан үзэх ёстой урт хугацааны хэтийн төлөв болох хандлагатай¹⁰ байна.

Академич Ц. Баатар Орчлонгийн нэгдмэл чанарыг оршихуйн үүднээс тайлбарлахыг оролддог тодорхой шинжлэх ухаануудын онолын судалгаанд янагуух үнэн ба үнэмлэхүй үнэн хоёрын харилцааг гаргахад тохиолдож байгаа бэрхшээлийг тодорхойлж, “Орчлон тэлсээр байгаа нь нотлогддог. Үүнээс хамааран янз бүрийн судалгаа явуулж байна. Бид учиргүй мухардалд орчихоогүй. Гэхдээ 100 хувь таньж мэдээгүй. Таталцлын харилцан үйлчлэл, цахилгаан соронзон орон, сул, хүчтэй харилцан үйлчлэл гэсэн дөрвөн зүйлийн нарийн учрыг олоогүй цагт дэлхий ертөнц, харилцан юмсыг бүрэн ойлгоход бэрх”¹¹ гэж дүгнэжээ. Тусгай шинжлэх ухаануудын онолын судалгаанд тохиолдож буй энэ бэрхшээлийг ахуй ёс, танин мэдэхүйн түгээмэл зүй тогтлын үүднээс зөв тайлбарлаж чадах арга зүй нь өрнөдөд орчин үед философийн хермэнойтикийн феномэнологи болж байна¹².

Орчлонгийн жам ёс хүмүүний оршихуйн зохицол болох талаас нь дорно дахины философи эхлэн судалсан бөгөөд хүний нийгэмд түүнийг тогтоох туршлага нь сайн ба муу үйлийг сөргөлдүүлэн үнэлэх биш харин тэднийг шүтэн барилдахуйд нь авч үзэх ёстой гэдэг байв¹³. Бидний улс нэн эртнээс оюуны хэлхээ холбоотой явж ирсэн энэтхэгийн философид Орчлонгийн жам ёсыг төрөн үүсэх ба төрдөж үгүй болохын эх үүсвэр, нэгдмэл нэг субстанц гэж үздэг байжээ. “Энэхүү нэгдмэл субстанцад нь төрж үүсэх, төгс бүрдэх ба түрдэн үгүй болох гурав хийсвэрээр агуулагдаж байдаг”¹⁴ гэж Хээгель тэмдэглэсэн авай.

Философи тусгай шинжлэх ухаануудын онол, үзэл баримтлалуудыг илүү өргөн, түгээмэл хам холбоонд авч үзэж, ач холбогдлыг нь шинжлэн гаргаж, ойлголт категориудыг зөв хэрэглэх горимыг тодорхойлж өгдөг. Нэр томъёоны агуулга өөр өөр байх, үзэл баримтлал нарийн түвэгтэй байх нь сэтгэлгээний өөр өөр төвшин, түрүүлсэн болон зэрэгцээ сэтгэлгээтэй холбоотой тул судалгаанд Орчлонгийн үүсэл хөгжлийн оюун санааны түлхүүр

¹⁰ Жадамба Б. Үйлийн судалгааны квант онол. УБ., 2016. Х. 7-11

¹¹ Баатар Ц. <https://dnn.mn/>. Эрдэмтэн бидний судалгаа дэлхийн шинэ нээлтийг гаргахад хувь нэмрээ оруулдаг.

¹² H-G Gadamer. Wahrheit und Methode. I.C.V. Mohr (Paul Seabeck), Nubingen. 1960,

¹³ Монгол барын улаан шунхан Данжуур.УННС Нэн ховор номын хөмрөг.Ганжуур.Модон бар.УННС, Мэргэд гарахын орон хэмээх тогтоосон дияг оршивой.УННС

¹⁴ Гегель. Философия истории. Соч., Т. ҮШ, М-Л., 1935.

үзэл баримтлалыг бүх асуудалтай холбон хам хэрэгжүүлэхийг оролдов. Орчлонгийн жам ёсыг тайлбарлах үзэл баримтлал өөртөө шинжлэх ухааны мэдлэг, соёл, хүрээлэн буй орчин, эдийн засаг, технологи, нийгмийн зэрэг нарийн төвөгтэй олон асуудлыг агуулж байдаг тул судлагдахууныг хүн, нийгэм, байгалийн шүтэн барилдахуйд эргэцүүлэх шинжлэх ухаануудын хоорондын хамтын ажиллагааг шаардав. Оюуны ертөнцийн билгэ чанарыг “орчлонд ирэх ба одохуй, онож гэгээрэхийн уг үндэс оюун сэтгэхүйд буй” гэж дүгнэсэн Агваанбалдангийн гаргалгаа манай судалгааны онол, чойрын үндэс болж байна. Энэ бүхэн Орчлонгийн жам ёсыг үнэн зөв тайлахын тулд өрнө дорнын сэтгэлгээний түлхүүр үзэл баримтлалуудыг харьцуулан судалж (comparative studies), орчин үеийн шинжлэх ухаануудын уулзварт ажиллахыг шаардаж байна.

Орчлон, ертөнцийг бүхэл нэгдэл, шүтэн барилдахуйд нь авч үзэх. Орчлон ертөнц бол бие биетэйгээ шүтэн барилдаж, торлогдон холбогдсон тусгай онцгой зүйлсийн шүтэн барилдсан бүхэллэг бөгөөд олон төрөл зүйлийн өвөрмөц шинжийн нэгдэл болж байдаг. Орчлон эгэл бөөмсөөс эхлэн асар том од гарагийн аймаг, хэт чавхдас хүртэлх тусгай тусгай олон төрөл зүйлээс тогтдог нь эмхгүй гэсэн үг биш харин тэр олон янз байдал нь нэгэн бүхэллэг болж, түүнд нь нэгэн бүхэллэгийн шүтэн барилдахуйн хамгийн түгээмэл зүй тогтол үйлчилдэг ажээ. Харин хүн төрөлхтөн бүхэллэгийн түгээмэл зохицол, шүтэн барилдахуйг хараахан бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрөөгүй байгаа учир хөрөнгө оруулалт ихээр шаардах технологийн хүчээр ертөнцийн жам ёсны хөгжилд хөндлөнгөөс оролцдог нь санаатай биш ч гэсэн урьдаас таамаглах аргагүй, эмх журамгүй, хүсээгүй үр дүнд хүргэх нь олонтаа. Үүний үр дагавар болж экологи, нийгмийн болон оюуны ертөнцийн хямралт олон асуудал үүсч байгаагийн гол шалтгаан ертөнцийг бүрэн танин мэдэж чадаагүйд оршино.

Орчлонгийн бүхэллэг чанарыг таньж мэдэх оюун сэтгэхүйн оролдлого, тайлал нь дорно дахинд байгалийг ойлгох явдал хүний гэгээрлийн суурь үндэс мөн гэх үзлээс эхтэй. Манай уламжлалт соёлын салшгүй бүрэлдүүн болж нэгэнт хэвшсэн Буддын философийн бэлгэ чанар нь ертөнц бүхэлдээ хүнээс шалтгаалан нөхцөлдөж, шүтэн барилдаж байдаг гэж, түүнчлэн бүх оршигч, түүний дотор хүн өөрөө байнга эрч хүчтэй өөрчлөгдөгч (анитья) шинж чанартай гэж баталдагт оршино. Будда брахманы философи шиг хүн бие ба огт хувирдаггүй сүнс (анатма-вада) хоёроос тогтдог гэж үзээгүй, харин бие болон оюун санааны мэдэгдэхүүнийг бүрэлдүүлж, мөхөөж байдаг дхармуудын таван бүлэг махбодоос

(скандх) тогтдог гэж сургасан билээ. Гэхдээ энэхүү түгээмэл өөрчлөгдөгч чанартай дхармууд шүтэн барилдаж үүсэх хууль(пратитья-самутпада)-нд захирагдах тул эмхгүй буюу хаос биш амой. Монголын мадхьямакч Агваанбалдан “алив юм шороо, гал, ус, хий хэмээх дөрвөн махбодиос бүтээд тэр нь зохицолдож сайн болоод дараа нь зөрчилдөж хямраад эвдэрдэг болой” гээд “бас тэдний дээр тав дахь махбод болох огт оргүй махбод бий”¹⁵ гэжээ. Үүнээс хоёр мянган жилийн дараа Ертөнцийг амьд организмтай адилтган үзэх тайлбарлал Европ дахинаа үүссэн нь урьдаас тогтоосон зохицлын онол гаргасан ХҮП зууны В. Г. Лайбницын¹⁶ нэртэй холбоотой. Мөн түүнчлэн байгалийг үзэх цэвэр механик үзэл баримтлалыг Т. Хоббес шүүмжилж байсан билээ. Рэне Декарт Аристотелийн энтелехийн тухай санааг үргэлжлүүлэн “”материйн хамгийн жижиг хэсэгт ч ертөнц өөрөө, амьд бие, амьтад болон сүнс агуулагдаж байдаг нь ургамлаар дүүрэн цэцэрлэг, загасаар дүүрэн цөөрөм лугаа адил” хэмээн нотлохыг оролдож байв. Тэдний хувьд тогтвортой чанарын үзэл санаа нь тэдгээр амьд нэгдлийг хүрээлэн буй нэгэн эрүүл орчинд сайн сайхнаар нь, эвдрээгүй хамтын нийгэмлэгт нь хадгалан үлдээхэд оршиж байв.

Судалгааны зорилго, зорилтууд. Дорнын мэргэн ухааны нэг монголын буддын философийг өрнө дахины орчин үеийн философийн тэргүүлэх чиглэлтэй харьцуулан философийн тайлал зүйн мэдэгдэхүүний билиг хэмээх шинэ эргэцүүллийг гарган түүнийгээ шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, шинэ онолуудыг тайлбарлах, тогтвортой хөгжлийн оюун санааны үндсийн тухай баримтлалыг боловсруулахад хэрэглэх зорилготой. Энэ зорилгоос судалгааны дараах зорилтууд урган гарч байна. Үүнд:

-Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтлуудыг бүхэлд нь их нэгдлийн үүднээс тайлбарладаг метафизик ба шинжлэх ухааны үзэл баримтлалуудыг задлан шинжлэх

- Хоёр. Орчлонгийн хараахан бүрэн тайлагдаагүй зарим зүй тогтлуудын тухай онолуудыг задлан шинжлэхэд философи ба космологи, астрофизикийн шүтэн барилдахуйн хамаарлын шинэ үндэслэлийг гарган томъёолж өгөх.

¹⁵ Chos mngon pa mdsod kyi hdogs bead, x. 28b

¹⁶ Leibniz 1720, Monadologie n. 66-67, S. 471

- Орчлонгийн жам ёсны тухай байгалийн шинжлэл, техник, технологийн шинэ онол, хандлагын философийн үндэслэл, тайлбаруудыг шинэчлэх

- Хүмүүнлэгийн ертөнцийн жам ёсны түгээмэл зүй тогтлын шинжлэх ухаанч философийн шинэ үндэслэгээг дэвшүүлэх

Судалгааны онол, арга зүйн үндэс нь Дорнын уламжлалт болон өрнийн орчин үеийн философийн эш онолын дэвшилтэт ололтыг харьцуулан судлах компаратив ерөнхий арга зүй, шүтэн барилдуулж тайлах мэдэгдэхүүний билиг мөн. Энэ судалгаанд “Орчлонг танин мэдэхүйн тулгамдсан асуудлууд”-ыг шинжлэн тайлах орчин үеийн хермэнойтик феномэнологи, коммуникатив үйлдлийн онол болон монголын буддын философийн уламжлалыг зэрэгцүүлэн хэрэглэсэн болно.

Судалгааны шинэлэг тал. Философийн компаратив судалгааг ашиглан шинжлэх ухаанч философийг эргэцүүллийн шинэ өндөр түвшин, ойлгохуй ба тайлбарлахуйн гүн тогтолцоонд гаргах оролдлого хийсэн. Үүнд:

-Космологийн энтроп шинжийг шүүмжлэлтэй судлан квантчлагдсан орон, хугацааны шинэ онолд түшиглэн хэт том хэмжээст (космологийн) болон хэт бага хэмжээст (квантын) хамаарлууд хугацааны олон хэмжүүрээр илэрдэг нь долгион орны хоосон чанар, агшин ба галавын дхармын агуулга, шугаман биш, нэг хэмжээст биш өөрчлөгдөгч Орчлонгийн шүтэн барилдахуйн түгээмэл хуультай дүйж буйг харуулахыг оролдсон.

-Мэдээллийн нийгэмд интернетийг бүтээн ашиглах болсон нь онтологийг өргөтгөн танин мэдэхүйн энгийн хувьсгалаас илүү өргөн утга агуулгыг бий болгож, онтологийн бус асуудлыг онтологид оруулан судлах шинэ боломж нээж байгааг онолын хувьд үндэслэв.

- Орчин үеийн квант болон харьцангуйн онолын монголын буддын философийн тайлбарыг анх удаа хийж, оюун бие хоёрыг шүтэн барилдуулж, объект субъектийг байнга өөрчлөгдөгч нэгдэлд нь авч үздэг арга зүй боловсруулав.

-Нэг нэгдмэлийн илэрхийлэл тэгш хэм нэрийтгэлийн (ноумэн) чанартай байх атал олонлог нь мэдэгдэхүүний (феномэналь) шинжтэй учраас алив тэгш хэм заавал зөрчигдөх зүй тогтолд үндэслэн шинжлэх ухааны танин мэдэхүй ямагт мэдэгдэхүүний билигээс нэрийтгэл зүйд, түүнээс эргээд дахин мэдэгдэхүүний билигт, баримтат чанараас онолын загвар бүтээхэд, түүнээс эргээд дахин мэдэгдэхүүн (феномэн)-д шилждэг ойлгох, тайлбарлах орчил мөн гэдэг үндсэн зүй тогтлыг шинээр боловсруулж өгсөн.

-Зөвхөн “Homo sapiens”-ийн хүрээнд баригдан антроморф шинжтэй байсан сонгодог философи түүнээсээ гарч, физик ба биологи хоёрын судалгааг нэгтгэн ойлгож чадсанаар Орчлонгийн түгээмэл зүй тогтлыг бүхэлд нь тайлж чадах шинэ астрофилософи үүсэх боломжит чиглэлийг таамаглан дэвшүүлэхийг оролдсон болно.

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндэс болж буй ашиг тусын үзэл санаанаас байгаль, нийгэм, хүний хам тогтолцооны шүтэн барилдахуйн үзэл санаанд шилжих зүй тогтолд суурилан хүмүүнлэгийн ертөнцийн философийг шинээр үндэслэж өгсөн.

Нэгдүгээр бүлэг

Оюун санааны гол цөм нь шинжлэх ухааны мэдлэг болдог түгээмэл зүй тогтол. General regularity of scientific knowledge becoming the main core of the soul

Манай үед ертөнцийг үзэх үзлийн үлгэр загвар өөрчлөгдөн солигдох хандлага тод ажиглагдах боллоо. Өрнөдийн техникийн гаралтай соёл иргэншилд онц хүчтэй ноёрхож ирсэн хэт объективчлогдсон цэвэр шинжлэх ухааны мэдлэгийн халдашгүй нэр хүнд ба рационал ухааны түлхүү байр суурь өөрчлөгдөж байна. Шинжлэх ухааны суурь үндсийг бүхэлд нь хөндсөн гол гол өөрчлөлт гарч, оюун санааны орон зайд түүнийг шинээр тодорхойлох шаардлага үүсчээ. Шинжлэх ухааны мэдлэгийн явцуу ойлголтыг “соёл ба оюун санааны ухаан”-ы бүхнийг хамарсан, түгээмэл зүй тогтолд хүртэл өргөтгөх, өөрийнх нь оюуны эх сурвалж, үндэслэлээс салгаж үл болох мэдлэг бүрэлдэн хөгжих боломж, хэтийн төлөв хэдийн нээгдэв. Шинжлэх ухаанд философийн эзлэх байр суурь, үүрэг, ач холбогдлыг эргэн харах, соёл иргэншлийн өргөн хүрээнд “философи”, “шинжлэх ухаан”, “урлаг” хэмээх ойлголтуудын хүрээ, хаяалбарыг бүхэлд нь өргөтгөн тодорхойлох асуудал тулгарав. Эдүгээ өрнө дорно хоёр илүү нягт холбогдож, харилцан ярилцах, ойлголцох болсноор Орчлон ертөнцийг бүхэлд нь ойлгох үйл явц шинэ шатанд гарч байна. Хүн төрөлхтний оюуны хувьслын түүхэн үйл явц, түүний когнитив арга чадварыг өрнө дорнын соёл харилцан баяжихын үндэс болсон дэлхийн философийн хэлэлцүүлгийн хам бүрдэлд танин мэдэхүйн шинжлэх ухааны, философийн болон уран сайхны хэлбэрүүд адил үнэ цэнэтэй гэж үзэх болов.

Герэг, ромын соёл иргэншлээс эхтэй өрнөдийн сонгодог философийн монист материализм болон монист идеализмын аль аль нь мухардалд орж, арга зүйн чадамж нь барагдаж байна. Ийм нөхцөлд шинжлэх ухаанч философи хязгааргүй хурдан өргөсөн тэлж буй Орчлонгийн нууцыг тайлахын тулд хүн төрөлхтний эртний уламжлалт мэдлэг, нэн ялангуяа дорно дахины философийн их өв уламжлалд хандах нь их болжээ. Орчин үеийн шинжлэх ухаанч философийн гол хандлага болох хермэнойтик феноменологийг дорнын уламжлалт философийн тайлал зүй, мэдэгдэхүүний билгийн онол арга зүйтэй харьцуулан, шинжлэх ухаан, технологийн тэргүүний ололтонд тулгуурлан шинэ, шинжлэх ухаанч

философийг бүтээх боломж байна. Ялангуяа өрнө дорнын соёл иргэншлийн уулзварт хөгжиж ирсэн манай философчдын хувьд харьцуулан шинжилж, алив дэвшилт санааг шүтэн барилдуулж, улмаар түүнд үндэслэн философийн эргэцүүллийн гүн тийш шинэ алхам хийх нь дэлхийн философийн түвшинд хүрэх зам мөн.

Нэг. Философи шинжлэх ухаанч болох арга зам (Ways and methods of formation of scientific philosophy)

Бүх юмны оршихуйн философийн шинжилгээ буюу **ахуй ёс** болох онтологи хэрхэн өөрчлөгдөж байна вэ?. Өргөн утгаараа ахуй ёс нь ахуйд шууд хамаарах үүсэл хөгжил, ахуй, бодит байдал мэтийн ойлголтууд болон ахуй ёсны үндсэн категориуд, тэдний хоорондын харилцааг судалдаг философийн үндсэн салбар билээ. Өрнийн сонгодог философид ахуй ёсыг метафизик гэж нэрлэн ямар мөн чанарууд оршдог болон оршигч гэж нэрлэгддэг тэднийг шинж чанараас хамааран хэрхэн ангилж, суварган бүтцэд оруулж, хэлхээ холбоог нь тогтоодог тухай асуудлуудыг тайлбарлаж ирсэн уламжлалтай. Метафизик дэг журам нь нөгөө талаас, философи нь оюун санаа, сүнс сүлдний дотоод сэтгэцийн байгууламжийн тусгал мөн гэдгийг илтгэн үзүүлж байдаг. Метафизик гэдэг бол орчин үеийн философид юм үзэгдлийн шинж чанарын **хамгийн суурь түгээмэл зарчмыг судлахыг** хэлдэг.

Философийн тайлал зүйн онтологийн үндэслэл (The ontological Foundation of the philosophical hermeneutics). Юм үзэгдлийн оршихуй, орон ба хугацаа, Орчлонгийн түгээмэл зүй тогтлыг тайлбарладаг философийг монголын буддист уламжлалд ертөнцийн жам ёсны дээд хуулийн ном (Дхарма) хэмээх бол өрнийн сонгодог ухаанд метафизик гэж нэрлэдэг. Метафизик бол бодит байдал ба Орчлонгийн бүх оршигчийн ахуйн хязгааргүй шинж чанар, түгээмэл хуулийг судлан тайлбарладаг философийн үндсэн салбар бөгөөд **бодит байдлын шинж чанар, Орчлонд хүний эзлэх байр суурь, бодит зүйл ба санаалаг зүйл ямар байх болон оюун ухаанаас гадуур ертөнц оршдог эсэх, бодит объектууд, үйл явдал, орон, хугацаа ба баримтат чанар ямар шинж чанартай байх асуудлыг** судалдаг.

Метафизикийн хамгийн гол салбар нь ертөнцөд юмсын ямар төрөл хэлбэрүүд оршдог хийгээд тэд хоорондоо хэрхэн харилцдаг тухай асуудлыг судлан шинжилдэг **ахуй ёс буюу (ontology)** юм. Ийм судалгаа хийхийн тулд оршихуй, судлагдах байдал, шинж чанар, орон, хугацаа, шалтгаал ба бололцоо зэрэг ойлголтуудын агуулгыг тодруулан ашигладаг. Онтологийн үндсэн судлагдахуун нь оршин буй юм, бодит байдлын бүх хэлбэр (бодит,

объектив, физик гэх мэт болон субъектив, нийгмийн ба виртуаль зэрэг)-ийн иж бүрдэл ба нэгдэл гэж тодорхойлогдог ахуй мөн. Философийн “ахуй” хэмээх ойлголт нь суурь онтологийн арай явцуу утгаар байгаа юмны оршихуйн талыг түүний өөрийнх нь мөн чанараас ялган гаргаж үзэх авай. Үүнээс ургуулан үзвэл, “Байж байгаа юм гэж юу юм бэ?” гэдэг асуултаар тухайн юмны мөн чанар тодорхойлогддог аваас харин “Юм байж байна гэдэг юу юм бэ? хэмээх асуулт ахуйг тодорхойлж өгөх учиртай.

Орчин үеийн шинжлэх ухаан хөгжих хүртэл шинжлэх ухааны асуудлуудыг "натурфилософи" гэж нэрлэдэг амьдрах ухаан буюу метафизикийн нэг хэсэг авч үздэг байсан бөгөөд “шинжлэх ухаан” гэдэг нэр томъёо нь “мэдлэг”-ийг хэлдэг байв. Монголын философийн түүхэнд ч ийм байв. Метафизикийн үндсэн категори болох “ахуй” гэдэг ойлголтыг монголын философийн утга зохиол, эргэцүүллийн хэлэнд анх ашиглаж эхэлсэн тухайд гэвэл эртнээс нааш монголчуудын философид зонхилох байр эзэлж байсан бөө мөргөлийн үзэл, бөөгийн ёсны аман дуудлага, бичвэр ба баримт эхнийх нь болой. Академич Ц. Дамдинсүрэн багшийн эмхэтгэсэн “Монголын уран зохиолын дээж Зуун билиг оршвой” хэмээх бүтээлд орсон бөөгийн залбиралд: “Ахуй их түгээмлийг Асар их тэтгэгч Мөнх хөх тэнгэр минь”¹⁷ гэж дурьдаж буй нь ерийн илт утгаас гадна хамгийн ерөнхий, түгээмэл оршихуй болох Орчлонгийн жам ёсноос заяат монгол хүмүүний ахуйд хандах философийн тайллыг илтгэж байна. Нэн эртнээс нааш даруй мянгаад жилийн турш Монгол үндэстний амьдрах ухааны философи, үйлийн боловсрол, хүмүүжил, соёлын ерөнхий үндэс болсоор ирсэн “Оюун түлхүүр” шастирт “Ер хүний ахуй үйл яршигтай Амьтны сэтгэлийг мэдэшгүй”¹⁸ тул, “өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн”¹⁹ хэмээн тайллын эргэцүүлэн бодох оньсон холбоог тодорхойлчихуй. Монголын философи “байх”-ыг эд юмсын тодорхойлолтонд, “оршихуй”-г амьд ертөнцийн хүрээнд хэрэглэж, харин “ахуй” гэдэг ойлголтыг хүмүүний оршихуйн тодорхойлолтонд тус тус ялгамжтай хэрэглэж ирсэн нь монгол хэлний баян тансаг, нэр томъёо нь гүн утгатай болохыг харуулдаг.

Монгол философид ахуйн тухай сургаалыг “ахуй ёс” хэмээн тэмдэглэж иржээ. “Мэргэд гарахын орон”-нд ахуй ёс (төвдөөр Gnas Lugs, самгардиар Tathatva гэдэг)-ны

¹⁷ Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын дээж Зуун билиг оршвой. УБ., 1959. Х. 29.

¹⁸ Оюун түлхүүр нэрт шастир оршвой. УБ., 2007. Х. 28

¹⁹ Мөн тэнд, Х. 20

механизмыг “Ахуй ёсны утгыг онохуй дор, Зургаан барамидыг төгсүүлэхүй дор, Хоёр тусын явдал дор, Ариун үзэл дор зохиогч”²⁰ хэмээн тодорхойлсон байдаг. Ер нь монгол хэлний ёс гэдэг үг юм, үзэгдлийн зайлшгүй зүй тогтол, хүний даган баримтлах хэв хуулийг тэмдэглэдэг тул онтологийг ахуй ёс хэмээн нэрлэж иржээ.

Орчин үеийн шинжлэх ухааны үүднээс оршихуйн үндсэнд гурван суурь хууль үйлчилж байна. Эдгээр нь, 1) термодинамикийн нэгдүгээр эхлэл: 2) энтропи өсөн нэмэгдэх суварган бүтэцт хувьслийн хууль (А. Хазены хууль): 3) өөрөө зохион байгуулагдах хууль, бүлэг хууль болно. Эхний хууль нь оршихуй буюу хөдөлгөөний анхны шалтгааны агуулгыг илрүүлж өгдөг бол энтропи өсөн нэмэгдэх суварган бүтэцт хувьслын хууль (А. Хазены хууль) мөн чанарын оршихуйд илэрдэг. Гуравдахь бүлэг хууль бодит чанарын хэлбэршил бүрэлдэх агуулгыг илрүүлж өгдөг. Оршихуйн гурван үндсэн шинж чанар нь урдаас тодорхойлогдсон, чиглэлтэй, эргэлт буцалтгүй. Оршихуйн чиглэлийн баримт нь термодинамикийн хоёрдахь эхлэлээс үүдэн гардаг гэдгийг шинжлэх ухаан болон философид нийтээр хүлээн зөвшөөрсөн билээ. Маргаантай байсан энэ шинж чанарыг анх үндэслэсэн эрдэмтдийн нэг нь Р. Пенроуз бөгөөд түүнийхээр, Орчлонгийн зохион байгуулалтын загвар зүй зохист хийн загвартай тохирно гэж үзвэл, хувьслын чиглэлийг “нам” энтропитой тогтолцооноос “өндөр” энтропитой тогтолцоонд шилжих шилжилттэй холбон тайлбарладаг. Орчлонгийн зохион байгуулалтын бүтцийн ийм агуулга оршихуйн урьдаас тогтоогдсон шинж, материаллаг ертөнцийн хөгжлийн урьдаас тогтоогдсон шинжтэйг, дараагийн үйл явдал бүхэн өмнөх үйл явдлаар тодорхой магадлалтайгаар тодорхойлогддог болохыг харуулж байна.

Тусагдахуун ба тэдний шинж чанарын метафизик. (Metaphysics - Objects and their properties: Problem of universals). Ахуйн үндсэн хэлбэр Орчлон ба байгалийн үйл явц болон хүмүүний үйлдвэрлэсэн юмсын ахуй, хүмүүний өөрийнх нь ахуй, оюун санааны ахуй, нийгмийн ахуй зэрэг болой. Орчлонд асар том галактикаас авхуулаад маш жижиг бөөмс хүртэл олон бодит юмс, хайр, ардчилал, “З”-ын тоо мэтийн хийсвэр зүйлс байх бөгөөд тэд өөр өөрийн өвөрмөц чанартай тул тусгай онцгой зүйл гэж нэрлэдэг. Эдгээр нэгж, тусгай бүхэнд бүгдэд нь, эсвэл зарим бүлэг, хэсэгт нь оршихуйн ижил нийтлэг арга, шинж чанар

²⁰ Агваанбалдан З. Илт онолын чимгийн үг, утгын үүднээс номлосон шастир, Майдарын нүүрийн эшлэл нэрт оршвой. УБ., 2017. Х. 110.

бас байх бөгөөд үүнийг ерөнхий гэж нэрлэдэг. Ийм зүйлс ба тэдний тогтвортой хэлхээ холбоог түгээмэл шинж чанар (универсалии) хэмээх бүлгээ. Түгээмэл ба тусгай онцгойн харилцааг судалдаг зарим философичид ерөнхий шинж чанар бол хийсвэр тусагдахуун бөгөөд орон ба хугацаанаас үл хамааран тодорхой тусагдахуунуудтай онцгой харилцаатай байдаг гэдэг. Нөгөө зарим нь тусгай онцгой гэдэг нь тусагдахууны өөрийн шинж чанаруудын хэлхээ холбоо, нэгэн цогц мөн гэж үздэг байна. Үүнтэй холбоотой өөрийнхөөрөө байх **адилцахуй ба өөрчлөгдөхуйн** (identity and change) асуудал, орон хугацааны философийн асуудал гарч ирдэг. Адилцахуй нь тоон адилцал, тэгш хэмд үндэслэдэг бөгөөд “юм” өөртөө хандах, нэг ч “юм” өөрөөсөө өөр юунд ч хамаагүй, өөрөөрөө байх харилцаа юм. Гэхдээ хугацаа өнгөрөхийн хэрээр тусагдахуунууд өөрчлөгдөж байдаг. Адилцахуй ба өөрчлөгдөхуй хоёрын хоорондын хэлхээ холбоог тайлбарладаг өрсөлдөгч хоёр онол байдаг нь пердурантизм ба эндурантизм билээ. Эхнийх нь өөрчлөгдөхүйг голлон мөрдөж, юм өөрчлөгдөх нь түүний оршихуйн хэд хэдэн өөр үе шат гэж үздэг бол хоёрдахь нь юм гэдэг өөрийн түүхийн үе шат бүхэнд, хэзээ ч хэвээр байдаг гэж баталдаг.

Орон ба хугацааны тухай сэцлэх ухаан (Philosophy of space and time and Spacetime). Ахуй ёсны материалист уламжлалын бодит байр суурь нь орон ба хугацаа хүний ухаанаас тусдаа оршдог гэж үздэг. Харин идеалистууд, тэдний дотор И. Кант орон ба хугацаа нь бодит биш бөгөөд хүртэж танин мэдэхүйн зохион байгуулалтанд ашиглагддаг сэтгэлгээний бүтээц хэмээн батладаг байв. Жишээлбэл, ширээний ард суугаа хүний өмнө буй алим орон хугацаанд оршино гэж бодвол энэ баталгаа юуг заах ёстой вэ? Жишээ нь, тухайн алим байрлаж байгаа үл үзэгдэх гурван хэмжээст тортой адил гэх үү? Орчлонгийн бүх тусагдахууныг ахуйгаас бүрэн зайлуулжээ гэж үзвэл юу болох вэ? Орон маань “үл үзэгдэх тор” маягаар оршсоор л байх уу?

Декарт Лайбниц нар энэ асуултанд үгүй гэж хариулсан юм. Орон гэдэг бол физик тусагдахуунууд бие биетэйгээ холбоотой гэдгийг мэдэж болох бүтэц мөн тул физикийн тусагдахуунгүйгээр “орон” ямар ч утгагүй болно гэж тэд үздэг байв. Ньютон бүр өөр талаас нь, төгс төгөлдөр “контейнер” орон байдаг гэж батлахыг оролдсон. Эйнштейний харьцангуйн онол гарснаар оронг бүр өөрөөр тайлбарлах боломж нээгдсэн юм. Оронгийн бодит чанарын тухай энэ бүх мэтгэлцээн хугацаанд мөн адил хамаатай боловч хугацаа бас өөрийн гэсэн өвөрмөц асуудлуудтай. Хугацаа урсан өнгөрдөг гэдгийг эртний Европт

Парменид, хожим үед Ж. Мактагарт “Хугацааны бодит бус чанар” гэдэг бүтээлээрээ няцааж байсан билээ.

“Хугацааны зүү” хэмээн нэрлэгддэг хугацааны чиглэл ч оньсого хэвээр байсаар байна. Орчин үеийн физикчид суурь үндсэн хуулиуд хугацааны хувьд эргэж хэрэгжих боломжтой нөхцөлд “хугацааны зүү” бодит чанартай холбоогүй, “танин мэдэх боломжгүй” (emergence) шинжтэй бөгөөд термодинамикийн эмх журамгүй, тодорхойгүй хэмжээсний тоон үзүүлэлтээр л ойлгож болох үзэгдэл юм хэмээн батлах болов. Энгийнээр хэлбэл, нэг голын усанд хоёр удаа орж болно гэсэн үг. Эндуртантууд нэг л тусагдахуун хугацааны мөчлөг бүхэнд оршиж байдаг гэдэг бол пердуртантууд тусагдахуун бол киноны кадр шиг хугацааны хэсэг хэсгүүдээс бүрддэг дөрвөн хэмжээст мөн чанар хэмээдэг.

Оршихуйн түгээмэл зүй тогтлын онол Орчлон ертөнц ямар байж болох байсан тухай асуудал буюу зайлшгүй ба боломжит байдал(Necessity and possibility)-ыг бас судалдаг. Зайлшгүй байдлын үзэл санаа аливаа зайлшгүй баримтат чанар боломжит бүх ертөнцөд үнэн зөв байх ёстой, бид түүнийг өөрөөр төсөөлөх аргагүй гэдэг нотолгоонд үндэслэдэг. Боломжтой баримт гэдэг нь бүр бодит ертөнцөд биш ч гэсэн зарим боломжит ертөнцөд үнэн зөв байх чанар юм. Квант механик бид бүгд боломжит чанарын Орчлонд амьдардаг тул алив шалтгаант нөхцөлдөлгөө энд байх боломжгүй гэж үздэгээрээ энэ мулгамдсан асуудлыг улам бүр нарийн түвэгтэй болгож байна.

Шалтгаант нөхцөлдөлгөө ба дур зоргын эрх чөлөө (determinism and free will). Энэ хоёрын харилцааны үндсэн зүй тогтлыг метафизик тайлбарлахыг оролддог. Шалтгаант нөхцөлдөлгөө гэдэг үйл явдал буюу хамтын ахуй бүхэн хүний танин мэдэхүй, шийдвэр болон үйл ажиллагааг өөртөө багтаах бөгөөд өмнөх үйл явдлын тасралтгүй гинжин хэлхээгээр каузаль байдлаар нөхцөлдөж байдаг гэж үздэг философийн үндэслэл юм. Энэ номлол ямар нэгэн санамсаргүй, урсгалаар үүсдэг, нууцлагдмал бөгөөд ид шидээр бүтдэг үйл явдал гэж үгүй гэж нотолдог нь дур зоргын чөлөөт байдлыг үгүйсгэдэг.

Дур зоргын чөлөөт байдлын шийдвэрлэх асуудал нь ухаант хүмүүс өөрсдийн шийдвэр ба үйл ажиллагаанд хяналт тавьж чаддаг эсэхтэй холбоотой тул чөлөөт байдал ба шалтгаант нөхцөлдөлгөө хоёрын хоорондын харилцан үйлчлэл, жам ёсны хуулиуд шалтгаан нөхцөлдөлгөөтэй эсэхийг ойлгоход чиглэж байдаг. Шалтгаант нөхцөлдөлгөөг үгүйсгэн

зөвхөн чөлөөт байдлыг хэтрүүлэн үнэлдэг төөрөгдөлт үзэл санааг либертарианизм гэж нэрлэдэг. Энэ хоёр үзэл санаа харилцан бие биенээ үгүйсгэх биш харин хоорондоо зохицох ёстой гэж үздэг философичдыг компатибилистүүд гэдэг. Дорно дахины философийн номлолууд ихэнхдээ ийм байр суурьтай юм.

Космологийн метафизик (Metaphysics – Cosmology). Космологи бол орон хугацаан дахь бүх юм үзэгдлийг нийлбэр цогцод нь авч үздэг ухаан бөгөөд түүхийн хувьд асар өргөн хүрээтэй ихэнхдээ шашны номлолд суурилж байсан юм. Харин орчин үеийн метафизик космологи шинжлэх ухааны чинад, түүний хараахан хүрч чадаагүй байгаа Орчлонгийн холбогдолтой дараах асуудлуудыг философийн арга зүйгээр, шүтэн барилдахуйн болон диалектик аргаар тайлбарлахыг оролдож байна. Үүнд:

- Орчлон хэрхэн үүссэн вэ? Түүний анхдагч шалтгаан юу вэ? Түүний оршихуй зайлшгүй шинж чанартай юу? Эдгээр асуудлын үндсэн зүй тогтлыг хэрхэн тайлбарлаж байгаагаараа метафизик космологт монизм, пантеизм, эманационизм ба креационизм (monism, pantheism, emanationism and creationism)-ын үзэл баримтлалууд үүсчээ.
- Орчлонгийн хамгийн эцсийн материаллаг бүрдэл юу байх вэ? гэдэг асуултын хариуг механизм, динамизм, хиломорфизм, атомизм (mechanism, dynamism, hylomorphism, atomism)-ын сургаалууд эрэн сурвалжилж байдаг.
- Орчлон оршин байхуйн эцсийн шалтгаан юу байх вэ? Орчлонд зорилго бий юу гэх мэтийн асуулт? ч бас энд хамаарна.

Философи анх үүсэхдээ Орчлонгийн тухай, сансар, ертөнц түгээмэл өөрчлөгдөгч хоосон чанараас хэрхэн үүссэн болон түүний бүтэц, бүрэлдүүний үндэс болсон хамгийн жижиг нарийн тоосны тухай ухаан л байлаа. Философийн нэг ч том дэг сургууль, нэг ч агуу философич Орчлонгийн үүсэл, мөн чанар, байгууламж, сансар ертөнцийн шинж чанарыг судлаж ойлгохоос холуур өнгөрч байгаагүй. Философи хөгжиж ирсэн олон мянган жилийн түүх бүхэлдээ Орчлон, түүний үүсч хөгжсөн хамгийн түгээмэл хууль, зүй тогтлыг тайлбарлах, энгүй энэ дайдад хүмүүний ахуйн эзлэх байр суурь, үүргийг ойлгох оролдлого байв. Эдүгээ шинжлэх ухаан эгэл бөөмсийн харилцан үйлчлэлийн хүчний ачаар матери физик чанаргүй болдог конфайнмент үзэгдлээс нэгж нь тэрбумээр хэмжигддэг од гараг, хар

нүх хүртэлх матери, орон, хугацаа ба бүтэц, хөдөлгөөний талаар шинэ шинэ нээлт хийж, философийн тайлал зүйг урагш түлхсээр байна. Эгэл бөөмсийн физик, астрофизик ба космологийн орчин үеийн мэдлэг, харьцангуйн болон квант онол, хаос болон фракталын тухай үзэл баримтлалууд л хүний оюун сэтгэлгээг бүх түүхийн турш догдлуулж ирсэн метафизик космологийн асуудалд үнэн зөв хариу өгч чадна. Өөрчлөн шинэчлэгдэгч философи шинжлэх ухааны орчин үеийн ололт амжилтад тулгуурлан Орчлонгийн тухай түгээмэл онолыг боловсруулдаг төдийгүй ертөнцийн байгууламж дахь хүний ахуй, сэтгэлгээний ерөнхий зүй тогтлыг тайлбарладаг. Чухам үүнд л философийн үндсэн зориулалт, Орчлонгийн мөн чанарыг таньж мэдэх, түүн дэх хүмүүний ахуйн утгыг ойлгох, тайлах явдал оршдог.

Орчин үеийн философийн бүх асуудлын ерөнхий эргэцүүлэл, эрэл хайгуул нь эцсийн эцэст Орчлон дахь ертөнцүүдийн нэгдэл, байгаль, нийгэм, хүмүүн ба огторгуйн шүтэн барилдахуйг тайлбарлах нийтлэг онолд зайлшгүй хүрдэг. Дэлхийн таталцлын тухай Ньютоны хуулийн философийн үндсэн утга нь таталцлын харилцан үйлчлэл хязгааргүй хурдаар буюу агшин төдийд дамждаг гэдэгт байдаг. Биет хоорондоо харилцан үйлчлэх таталцлын хүч нь тэд огторгуйн ямар ч зайнд оршиж байгаагаас үл шалтгаалан хязгааргүй хурдаар агшин зуур дамждаг гэж үзэх нь таталцлын харилцан үйлчлэлийн орон ямар байхтай энэ хүч огт хамаагүй гэдгийг заах амой. Ньютоныхоор орон ба хугацаа төгс чанартай бөгөөд тэрхүү туйлын шинжтэй орон ба хугацаа дотор нь ямар ямар материаллаг үйл явдал өрнөж байгаагаас үл хамааран өөрчлөгдөшгүй, бүрэн төгс чанартай ажээ. Харин Эйнштейн ньтоны энэ орон бол материйг чихэн оруулж болох “хоосон хайрцаг” бөгөөд хэрэв материйг тэндээс эргүүлэн авбал “хайрцаг” материгүй болон хоосорч үлдэх болно гэж үзсэн билээ. Таталцлын Ньютоны онол ба Эйнштейний харьцангуйн ерөнхий онол хоёрын зарчмын ялгаа нь Эйнштейнд дээрх шиг “хоосон хайрцаг” байдаггүй, байх ч аргагүй гэдгийг харуулдаг. Эйнштейний орон ба хугацаа хэзээ ямагт материар дүүрсэн байх бөгөөд түүний орон-хугацааны бүтцэд матери бодитой байрладаг тул тэндээс материйг татаж аваад “хоосон хайрцаг”-ийг үлдээх аргагүй. Тэндээс материйг зөвхөн тэрхүү “хайрцаг”-ийн хамт буюу орон хугацаатай нь цуг авах ёстой гэдэг арга зүй юм.

Чингэж үзэхүл, физик сэтгэлгээний хөгжил нэг талаас, ертөнцийг нэгдэлд нь ойлгох философийн хөтөлбөртөө Эйнштейний гаргасан зураглалаар явагдаж байна. Нөгөө талаас,

ертөнцийг нэгдэлд нь ойлгох Эйнштейний философийн хөтөлбөрт космологи ба эгэл бөөмсийн физик хоёр ойртон нэгдэх тухай агуу их үзэл санаа бий. Ертөнцийг нэгдэлд нь ойлгох шүтэн барилдахуйн онолд гарч буй хамгийн тод үйл явдал бол бүхнийг нэвтрэн сүлэгч таталцлын хүчний тухай шинжлэх ухаан болох космологи ба суурь болон эгэл бөөмсийн тухай астрофизикийн шинжлэх ухаан хоёр “нэгдэн нийлж” байгаа явц мөн. Орчин үед нэрд гарсан эрдэмтэн Стийвэн Хоокинг гэхэд л өөрийн бүх бүтээлдээ Эйнштейний ХЕО-ын ач холбогдлын зөвхөн нэг тал болох сонгодог шинжийг байнга дурьдаж харин түүний квант чанартайг орхигдуулдаг байлаа. Гэтэл квант таталцлын буюу микротаталцлын онолыг бүтээх оролдлого ертөнцийг нэгдэлд нь ойлгох Эйнштейний философийн хөтөлбөртэй холбоотой бөгөөд түүний мөн чанараас урган гарч байгаа биш гэж үү? Агуу их суут эрдэмтэн А. Эйнштейний физикийн бүтээлүүдийг бид үнэлж цэгнэх ямар ч хэрэггүй нь ойлгомжтой. Харин бидний хувьд ертөнцийг нэгдэлд нь ойлгох Эйнштейний хөтөлбөрийн философийн тал нь маргашгүй ач холбогдолтой амой. Энэ нь ухамсаргүйн хүрээнд байнга нуугдаж байхаар барахгүй шинжлэх ухааны өөрчлөн бүтээхүй тодрон гийх зөн билгийн зөвхөн тэр л агшинд илрэн гардаг.

Бидний бодлоор, Эйнштейн өөрийн ХЕО-оо бүтээх тэр агшиндаа агуу их гурван зөрчлийг уран нарийн атал яруу сайхнаар шийдвэрлэж чадсан бөгөөд чингэж шийдэх арга нь тэгш хэм(symmetry)-ийн зарчим байсан ажээ. Үзэхүл, эхний зөрчил нь Ньютоны механик ба Максвеллийн цахилгаан эрч хүч хоёрын хоорондох зөрчил мөн. Ньютоны механикийн хуулиуудад байдаг дотоод тэгш хэм Максвеллийн цахилгаан эрч хүчний суурь хуулиудтай үл тохирдог. Энэ зөрчил Эйнштейн харьцангуйн тусгай онолоо бүтээснээр шийдэгдсэн. Ньютоны хөдөлгөөний хуулиуд Галилейн өөрчлөн байгуулагч бүлгүүдийн хувьд тэгш хэмтэй (Invariance) бол харьцангуй (relativistically) механикийн хуулиуд нь Лоренцийн өөрчлөн байгуулагч бүлгүүдийн хувьд тэгш хэмтэй байх ажээ.

Философийн метафизикийг тайлбарлах монголын буддын философийн үндэс нь **шүтэн барилдахуйн онол** мөн. Энэ шүтэлцээнд философийн энэ уламжлалын танин мэдэхүйн өөдрөг шинж чанар оршино. Бүх оршигчийн шүтэн барилдахуйн хууль орчин үеийн шинжлэх ухааны ололттой нийцэн бодит байдлыг дээрээс болон доороос нь хязгаарлах хаяалбартай зүйрлэж болохуйц төгс тодорхой (тусгай) ба төгс түгээмэл (ерөнхий) хэмээх ахуйн бүрэн төгс хоёр туйлыг ялган гаргах боломж олгох билээ. Энэ хоёр

Төгс чанарын хооронд харьцангуй бодит байдал ба мэдэгдэхүүний ертөнц цохилон оршдог. Мэдэгдэхүүний тайлал зүйтэй холбогдон метафизик ойлголт гэхээс илүүтэй түгших сэтгэлийн төлөв байдал гэмээр огторгуй махабодын тухай асуудал сөхөгддөг. Бидний бодлоор аюухуйн тухай Хайдэггерийн ойлголт Нагаржунайн үзэл санаатай адил төстэй бөгөөд үүнийг бас Билиг баримадаас олж харж болох ажээ. Хайдэггерийн гаргаж тавьсан ахуй ба оршихуйн хоорондын ялгаа ч монголын буддизмын нисваанисын ертөнцийн тухай сургаалын эргэцүүлэлтэй агаар нэгэн бүлгээ. Шүтэн барилдахуйн хуулийн үүднээс алив юмс маш өчүүхэн хумхи, тэдгээрийн тодорхой нэгдэл, дүрс ба хэлбэрийн цогцос болж буй болдог хэдий ч хөгжлийн зохих шатанд эвдэрч өөрчлөгдөх жамтай. Юмс эвдэрч түрдэхүй нь оргүйгээс шалтгаалдаггүй, мөн бас огт оргүй алга болдоггүй бодит үйл явц ажээ. “Шалтгаан үрийн холбооны үр дүн болон буй болж байгаа юм бүхэн өөрийн мөн чанараар хоосон”²¹. Буддын философийн онтологи нь мэдрэхүйн бодит ертөнцийг таван цогц, арван хоёр язгуур, арван найман төрөн түгэхүй, цувиралт ба цувирал үгүйн бүх дхарма хоосон чанартай гэдэг. “биет буюу үлэг нь махабодоос, махабод нь хумхийн тоосноос тогтох тухай сургаалыг бүхний суурь бөгөөд “материаллаг элементүүдийн харилцан холбоо, харилцан үйлчлэх, нэгээс нөгөөд шилжих байдлыг харуулж байна”²². “Агваанбалдангийнхаар манай мэдрэхүйн эрхтэнд тусгагдан буугдаж байдаг тэрхүү мэдэгдэхүүн нь мөнх юмс (дагва), бодит юмс (ойбо) гэж хоёр хуваагдах бөгөөд түүний бодит юмс гэгчид үлэг (вэмбо), мэдэл (шэйба), төгөлдөр бус хуран үйлдэхүй (данминьдүжэд) гурав багтах ажээ. Харин хумхын тоосны бөөгнөрөлөөр биелсэн бүхэн үлэг буюу биет зүйлийн эх үүсвэр болдог”²³ ажээ.

Онтологийн “эргэлт” (ontological "turn"). Оршихуйн үндэс нь бодис, эсвэл санаа байх ёстой гэж үздэг өрнөдийн монист философийн онтологи мухардалд орж, түүнээсээ гарахын тулд хэд хэдэн удаа онолын эргэлт, хувьсгал хийж байсан билээ. Эхлээд Кант танин мэдэхүй бол өөрийн өвөрмөц хуулиар явагддаг үйл явц гэж үзээд танин мэдэхүйн арга барил ба мэдлэгийг бүтээдэг зүйлийг тодорхойлдог гол хүчин зүйл нь танин мэдэгдэж буй субстанцын шинж чанар, бүтэц биш, харин танин мэдэгч субъектийн өвөрмөц чанар мөн гэснээрээ ийм эргэлт хийсэн. Кантынхаар, онолын философийн судлагдахуун нь байгаль, ертөнц, хүмүүн зэрэг алив юмсыг өөрийг нь судлах биш, харин танин мэдэх үйл ажиллагааг

²¹ Chos rje ngag dbang dpal ltan gyi rnam thar bzugs so, X. 2.

²² Жүгдэр Ч. Агваанбалдангийн гүн ухааны үзэл. УБ., 2007. X. 64-65

²³ Мөн тэнд, X. 61

шинжлэх, хүний оюун ухааны хууль ба зааг хязгаарыг тогтоох явдал ажээ. Чухам энэ утгаар Кант өөрийн философиийг трансценденталь гэж, арга зүйгээ шүүмжлэлт хэмээн нэрлэж байсан.

Туршлагын чинад буюу трансценденталь философи нь туршлага гэж юу болох, туршлагын өмнөх мэдлэг ба тэр хоёрын харьцааны асуудал, туршлагатай хамаагүй бодол эргэцүүлэлд анхнаасаа байсан, туршлагыг нөхцөлдүүлж өгдөг зүйлүүдийн ерөнхий зүй тогтлыг судалдаг. Тийм зүйлүүд нь Кантынхаар Орон, хугацаа, шалтгаант чанар, зайлшгүй байдал болон бусад категориуд байх ажээ. Мөн энд танин мэдэх боломжгүй, туршлагын гадуур мэдлэг болох трансцендент зүйлүүдийн судалгаа ч багтдаг.

Философийн тайлал зүйн ухааныг феноменологитой холбож хөгжүүлсэн нэрт философич М. Хайдэггер “Ахуй ба Хугацаа” гэдэг суурь судалгааны бүтээлдээ хүнийг ухаант амьтан, хувь хүн, сүнс, сэтгэл эсвэл субъект гэж үзэж оршихуйг тайлбарладаг өрнийн уламжлалт арга зүйн хийсвэр, метафизик шинж чанарыг шүүмжилж, ахуйг элбэрэх сэтгэл, хүний ахуй (*Dasein*) гэж тэмдэглээд оршихуйн боломжид сэргүүлэн тавьсан юм. Дазайн орчлон ертөнцийг үзүүлэх боломж биш харин боломжийн нөхцөл мөн тул хүмүүн өөрийн ахуйгаа бүтээж, өөрийн оршихуйн төлөө сэтгэл зовж, хариуцлага хүлээж байх өвөрмөц боломж бөгөөд тооцоолол ба нийгмийн амьдрал хоёрын темпораль чанараас ангид байх учиртай²⁴.

Энэ хоёр ажиглалт хугацаатай мөн чанарын холбоотой агаад Дазайн нь хугацааны юм болох тул ахуй ба хугацааны оршихуйн задлан шинжилгээ харьцангуйн тусгай онол харьцангуйн ерөнхий онолын “эцсийн тохиолдол” болсон шиг өрнөдийн уламжлалт философийн түүхийн хэл ба утгыг эвдэж өөрчлөх (*Destruktion*) “эцсийн тохиолдол” болох ёстой ажээ²⁵. Гэхдээ нэн ялангуяа Францын философид их дэлгэрсэн тооцоолол хэмээн тодорхойлж буй когитаци, машин гэж тодорхойлж байгаа амьд юм болон субъектив зүйлийг механикчлах алгоритмын дараалал хэмээн үзэх когнитив үйлдэл хүний танин

²⁴ Jacques Derrida describes this in the following terms: "We can see then that *Dasein*, though *not* man, is nevertheless *nothing other* than man." Jacques Derrida, "The Ends of Man", *Margins of Philosophy* (Chicago: University of Chicago Press, 1982), p. 127.

²⁵ Fehér, M., Kiss, O., & Ropolyi, L., *Hermeneutics and Science* ([Berlin](#)/Heidelberg: Springer, 1999), p. 216

мэдэхүйг кибернетик тогтолцоотой тэгшитгэн адилтгах онтологийн шийдэл дорнын хүмүүнлэг онтологиос эрс өөр юм. Оюун ухааныг механикчлах кибернетикийн хөтөлбөр алдаатай байсныг 1990-ээд онд дэлхийг нэлд нь бүрхсэн интернет бий болж, XXI зууны эхээр даяаршин тархсан явдал харуулж өгөв. Томас Куны томъёоллыг ашиглан хэлбэл, интернетийг бүтээсэн нь зүгээр нэг эпистемологийн хувьсгалаас илүү өргөн утга агуулгыг бий болгож байна. Орчлонгийн жам ёсны хуулиар оюун бие хоёрыг шүтэн барилдуулж, объект субъектийг байнга өөрчлөгдөгч нэгдэлд нь авч үздэг Дхармын дээд хуульд суурилсан энэ эргэлт нийгмийн нэргүй дүрслэлийн тасралтгүй үргэлжлэх бүтээлийн суурь үндэслэл, виртуаль бодит чанарт шилжих ахуйн шинэ хүрээ, онтологийн хувьсгал юм.

Өрнөдийн философийн уламжлалт метафизик баримтлал Орчлонгийн үүсэл хөгжлийг шалтгаан нөхцөлдөөний зарчимд захирагдсан зөвхөн урагшлахаас өөр сонголтгүй өсөн дэвших хөдөлгөөн хэмээн ойлгож ирсэн. Шалтгаан нөхцлийн хэлхээ холбоогоор хөгжлийн явцыг өнгөрсөн үе рүү хийгээд ирээдүй рүү ч тооцон үзэж болох бөгөөд сэргээн бүтээж бас урьдчилан харж болох ажээ. Орчлонгийн зохион байгуулалтын үндсэн зүй тогтлыг тайлбарлах ийм баримтлал марксист материализмын үед философи дахь ангийн тэмцэл болж хувирсан билээ. Олон ургалч үзлийг бүгд хүлээн зөвшөөрсөн өнөө үед ч зөвхөн ухааныг шүтэж, шинжлэх ухааныг хэт объективчилсон философидоо баригдсан өрнөдийн соёл сэтгэлгээ даяаршлалаар дамжуулан өөр соёл, өөр сэтгэлгээг үгүйсгэх, дарангуйлах, устгах оролдлого гаргасаар байна. Материалист монизм, идеалист монизм хоёрт хуваагдан онтологийн төдийгүй эпистемологийн мухардалд орсон өрнөдийн сонгодог философи өмнө нь рационализмыг гол болгон дорно дахинд философи байхгүй хэмээн нотлохыг удаан хугацаанд оролдож ирсэн билээ. Энэ бүхнийг өөрчлөх боломж харьцангуйн ерөнхий онол, квант механик үүссэнээр бий болгосон.

Үүнийг сөрөн зогсож, шинжлэх ухааны танин мэдэхүйн шинэ онолд хүргэх арга зүйг **төв замын философи** (санскритаар *madhyamā pratipad*, англиар *Middle Way*, оросоор *срединный путь*) гарган өгч чадна. Орчлонгийн жам ёсыг тайлан үнэнийг ухаарах төв замын тухай философи монголын буддизмын гол категори билээ. Монгол Ганжуурт “Алив хүсэгдэхүй жаргалангууд дор ашиглан хэрэглэж барилдуулахуй, доорд балгадын хувь бэртэгчин аран, хутагтан дор ариун явдлаар үл яван, дуранаа дарахуй үл болохуй, тачаангуйгаас хагацахуй үл болохуй, түридгүүлэгч үл болохуй, зөн билиг үл болохуй,

туулсан бодь хутаг үл болохуй, баринирван үл болохуй. Аливаа думдад мөр бус, биеийг чилүүлэн барилдуулагч, зовуулагч, ирээдүй дор бээр хоёр хязгаарыг тархааж бүрүүн, думдад мөрөөр бөгөөд, түүнчлэн ирсэн номыг номломуй”²⁶ хэмээн тодорхойлжээ.

Буддын их сэтгэгч Нагаржунагийн сургаалаас эхтэй монголын мадхьямака философи, түүний хандлагууд өнөөдрийн бидний мэдэх болсон квантын ертөнцтэй их л найртай сайн зохицдог. Түүний суурь үндэслэл энэ ертөнцөд бүхнээс тусгаарлагдсан, мөнхийн юм гэж юу ч байхгүй гэдэг тогтолцоонд оршдог. Бүх юмс өөрийн цаг зуурын оршихуйдаа зөвхөн тодорхой шалтгаант нөхцөлдөлгөө, шүтэн барихуйн ачаар л тогтдог. Харин тэр шалтгаан нөхцөлдөлгөө нь алга болоход бүх юм бас өөрчлөгдөн уусдаг. Материаллаг болон санаалаг нэг ч юм өөрийн эрхээр үл орших бөгөөд бүгд бие биетэйгээ холбоотой, шүтэн барилдаж оршдогийн үндэс суурь нь хүн өөрөө болой. “Хүн бол нийгмийн амьтан мөн” гэдэг уламжлалт ойлголт өөрчлөгдөж “хүн бол үйлдэгч, амьдралаа байнга шинэчлэгч”, “үнэн бол хүний үйл ажиллагааны үр дүн, ашиг тусаар хэмжигддэг зүйл” хэмээх утгаар нэмэгдэн баяжиж байна.

Хоёр. Монголын буддын философийн ахуй ёс (Ontology of the philosophy of Mongolian Buddhism).

Шүтэн барилдахуйн хууль. (The law of interdependence). Монголын буддын философийн бэлгэ чанар ертөнц бүхэлдээ хүнээс шалтгаалан нөхцөлдөж, шүтэн барилдаж байдаг гэж, түүнчлэн бүх оршигч өөрөө байнга эрч хүчтэй өөрчлөгдөгч шинж чанартай гэдэгт оршино. Бүхний ахуйн энэхүү зохицол, шүтэн барилдахуйн онолын үндсэн санаа:

- Эмхгүйгээс бүтцийн хувьд зохион байгуулагдсан шинэ тодорхой төлөв байдал үүсч байдаг. Энэ үйл явцын хууль зүй тогтлыг “хоосон чанар” тайлна:
- Маш нарийн төвөгтэй зохион байгуулагдсан, өөрөө зохион байгуулагддаг тогтолцоонуудад урсгал байдал, санамсаргүй нөхцөл их үүрэгтэй байдаг тул нарийн чанд тодорхой хуулиар хөгжиж чадахгүй “дхарма” ахуйтай:
- Нэгж, бөөмсөөс нарийн түвэгтэй хувьсагчийг үүсгэх, хэт байр суурийн зарчмууд, үйл явц арифметикийн дүрэм, физикийн хуулиуд, эвклидын геометрын горим зэрэгт захирагддаггүй фрактал чанартайг “авидхарма” тайлна.

²⁶ Хутагт аугаа ихэд цэнгэсэн. –Монгол Ганжуур. 61-р боть, X. 289, доорд, X. 290. Дээд.

- Шүтэн барилдахуй нь нарийн зохион байгуулагдсан тогтолцоонуудыг удирдах арга ба шинжлэх ухааны суурь философийн онол мөн. Чингэж удирдах гол оньсон хөшүүрэг нь хүч биш бөгөөд харин нарийн зохион байгуулагдсан тогтолцоонд нөлөөлөх олон талт нөлөөллийн шүтэн барилдсан зохицол болой.

Шүтэн барилдахуйн хууль, зүй тогтол нь зөвхөн математик, онолын физик, компьютерын технологи ба философийг нэгтгэн шалтгаант холбоог гарган харуулж, зохицлыг үндэслэж буй танин мэдэхүйн шинэ салбар төдий бишээ. Энэ бол биднийг хүрээлэн буй ертөнцийг тодорхойлж чадахуйц, хязгааргүй Орчлонгийн хаанаас ч олж болох философийн шинэ төрлийг нээх эргэлт, өөрчлөн байгуулалт юм. Энэ эрэл хайгуул юуны өмнө, асар томын шинжлэх ухаан астрофизик, агуу жижигийн шинжлэх ухаан эгэл бөөмсийн физик, огт оргүйн тухай ухаан космологи гурвын шүтэн барилдахуйн хүрээнээс эхэлж байна. Монголын уламжлалт философийн тайлал зүйн мэдэгдэхүүний билиг санамсаргүй, эмхгүй, шугаман бус гэх ойлголтуудаар илрэх чанарыг шүтэн барилдахуйн агуу их онолд хамруулан судалдгаараа хөдөлгөөн хөгжлийн тухай бусад үзэл баримтлалуудаас ялгардаг. Тухайлбал, диалектик ба хувьслын сонгодог үзэл баримтлалд санамсаргүйг ач холбогдол багатай, хоёрдугаар зэргийн бөгөөд цагийн эрхээр мартагдаж, орхигддог хүчин зүйл гэж үздэг бол мэдэгдэхүүний билиг түүнийг зайлшгүйн төвшинд авч судалдаг. Түүний хоёр үндсэн баримтлал нь “хоосон чанар” (shunya) ба шүтэн барилдахуйн ёс (pratita-samutpad) болой. Тэд нэг төрөл биш, адил тэнцүү биш, тэгш хэмт биш, тогтвортой биш эмхгүй төлөв байдлыг жам ёсны, жирийн чанар гэж үзээд түүнд бүтээлч үр дүнд хүргэж чадах хөгжлийн эх сурвалж, дэг журам нуугдаж байдаг гэдэг. Монголын буддизм “...маш нарийн тоосыг нэгэн язгуур хийгээд нэгэн төрөн түгэхүй ба нэгэн цогц мөн”²⁷ гэж ахуйг, хүний болон Орчлонгийн ухамсарлагдсан ахуйгаар агшнаас авхуулаад их галав гэж хугацааг тодорхойлдог. Тухайлбал “хүний мянган настай тэнцэх хугацааг бурханы нэг жил, хоёр түм дөрвөн мянган бурханы жилийг нэг галав хэмээнэ”²⁸.

“Хоосон чанар” (самгардиар शून्यता “шуньята”; бали хэлээр: “шунната”, англиар: “emptiness”, оросоор: “пустотность”) бол алив бодат “өөрийн мөн чанараар

²⁷ З. Агваанбалдан. Дөрвөн тогтсон тааллын ёсны янагуух хийгээд үнэмлэхүй утгыг номлосон сайн номлол хаврын охин тэнгэрийн дуулал хэмээх оршвой. //Монголын буддын философи. УБ., 2011. Х. 76

²⁸ Монголын философийн түүх. II дэвтэр. УБ., 2000. Х. 230

бүтсэн бус хоосон” гэх янагуухь үнэн, алив бодат “нэрийдлийн ачаар бий болсон бус хоосон” гэх мөнх тасархайн туйлшралыг хааж дундад замыг тэмдэглэдэг. “Хоосон чанар” юм бүхэнд түгээмэл байх бөгөөд эхлэлгүй цагийн махабод, юм бүхний орон мөний тул сав, шимийн ертөнцөд жам ёсны язгуур болж байдаг”. “Түүнийг мэдвээс түүн лүгээ утга нэг мөнх бусыг мэднэ. Гурван орны мөнх бусын дотор буйг мэдсэнээр түүнээс гэтлэхийг хүсэж хоосон чанарыг олж болно”²⁹ гэж монголын уламжлалт философи үздэг.

Орчлонгийн хөгжлийн тодорхой агшинд материйн эрчмийн нягтрал ба орон-хугацааны муруйлт планкийн агуулгаар асар их байх үеийн ба түүнээс хойших эрчмийн нягтрал маш их байсан хувьслын үеийг шинжлэх ухаанд Их тэсрэлт гэж нэрлэдэг. Их тэсрэлтийн үед үүсэх эрчим хүч асар их бөгөөд гурван хэмжээст ертөнцөд Орчлонг хоёр тийш нь хөгжүүлээд зогсохгүй эзлэхүүн орны хувьд түүнээс олон дахин том хар материйг бүтээжээ. Энэ төлөвийг мадхьямака философийн ойлголтоор илэрхийлбэл, нэг нь асар хурдан сарнин тархаж буй манай Орчлон (хуран үйлдэхүйн хоосон чанар) нөгөө нь түүнийг залгихаар хөөн ирж буй хар нүх буюу эрчмийн асар их нягтралтай нөгөө Орчлон (хуран эс үйлдэхүйн хоосон чанар) хоёрын дундах тэр хоёроос хоёулангаас нь асар том атал хэлбэр дүрсгүй агуу уужим талбар нь “хязгаараас нөгчигсөн хоосон чанар” буюу “эхлэл төгсгөл үгүйн хоосон чанар” болой. Чухам хоосон чанарын энэ төлөв байдлыг хүмүүс хэзээ ч даван гарч чадахгүй юм. Өнөөг хүртэл бид Их тэсрэлт рүү эргэн 14,3 миллиард гэрлийн жилийг шинжлэх ухааны хийсвэрлэлийн ачаар туулан таамаглаж байна. Бид хэдийгээр 15 млрд гэрлийн жилд ухран хүрлээ ч гэсэн одоо “хар матери” гэж нэрлээд байгаа оломгүй цагаан дайдыг хүний оюун ухааны эрчим ч туулж чадахгүй бөгөөд үүнийг л ХООСОН ЧАНАР гээд байгаа бус уу.

Хоосон чанар гэдэг ойлголтыг мөн сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, гүн увдисын бясалгалын төлөв байдлыг илэрхийлэхэд ашигладаг. Туршлагын таван шүтэн барилдахуй ба мэдрэхүйн зургаан хүрээний шинж чанарыг ч бас хэлдэг. Орчлонгийн бүх юм, үзэгдэл оюун ба биеийн, шалтгаан үрийн түгээмэл зүй тогтол болох шүтэн барилдахуйн нэгэн агшин төдийгөөс үл хэтрэхийн учир өөр өөрсдөө биеэ даан оршигч, үнэхээр бүтсэн юм нэгээхэн бээр ч үгүй болой. Энэ тухайд “Монгол Данжуур”-т “ нүдэн чихэн хийгээд хамар,

²⁹ Монголын философийн түүх. IY дэвтэр. УБ., 2001. X. 352, 357

хэл, бие, сэтгэл бээр зовлон, мөнх бус, оршил үгүй, би-үгүйгээр хоосон. Хаана нэр хийгээд дүрс би-үгүй тэр буй бус. Хамаг номууд эд шалтгаанаас барилдаж болмуй”³⁰.

Дхарма (/da:rmə /; самгардиар □□□□ гэж бичдэг сонсох, сэтгэл засах гэсэн анхны утгатай үг, монголоор ном гэнэ) гэдэг ойлголтыг ямар ч хэлэнд нэг үгээр орчуулан хэрэглэх аргагүй. Буддын философид Дхарма нь “орчлонгийн хууль, дэг журам”-ыг тэмдэглэх бөгөөд мэдэгдэхүүн зүй буюу феномэнологийн ойлголт байдаг. Монголын мадхьямака хүний гэгээрэл хөгжлийн замын найман гишүүн буюу алхмууд нь зөв сэтгэлгээ, зөв хэл, зөв санаа, зөв үйлдэл, зөв үүрэг тавилан, зөв чармайлт, зөв ухамсарлахуй ба зөв бясалгал хэмээн үздэг. Оршихуйн бүх арга хэрэгсэл хоосон чанар боловч Дхармыг мэдсэнээр үнэнд хүрч чадна. Дхарма бол Орчлонгийн жам ёс, үнэн, хөгжлийн замыг заагч байнга өөрчлөгдөгч философийн категори амой.

Абхидхάρма (самгардиар. **अभिधर्म**, abhidharma-үгчлэн орчуулбал “дээд хууль”, “дээд ном”, “эрхэм дээд сургаал” гэсэн утгатай); бали хэлээр **Абхидхамма**, хятадаар 阿毘曇/阿毘达磨 гэдэг) бол Орчлонгийн бүтэц зохион байгуулалтыг юуны өмнө, байгалийн болон ухамсрын юм үзэгдлийн зохицол хэмээн зөрчилгүйгээр ерөнхийлөн хийсвэрлэсэн буддын философийн метафизик сургаал юм.

Васубандху “Abhidharmakoshakarika” ном болон түүний тайлбартаа “мэдрэхүйн ертөнцийг нийт 75 дхарма болгон нарийвчлан ангилсан байдаг. Үүнд, танин баригч буюу онохуйн 47 дхарма буй нь: “Дүрс, сэтгэл, сэтгэлээс болсон, сэтгэл лүгээ адил төгөлдөр бус хийгээд хуран эс үүдсэн хэмээх таван цогц байна. Үүнээс дүрсийн цогц нь нүд, чих тэргүүтэн мэдрэхүйн таван эрхтэн, тэдгээрт өгөгдөгч дүрс, дуу тэргүүтэн таван утга (veshāi-утга буюу цул) болоод тэдгээр утгыг авч явагч ухамсар, сэтгэлгүй бие буюу тийн ухагч бус хэмээх нийт 11 дхарма буй.

Сэтгэл хийгээд сэтгэлээс болсон хэмээх нь ном буюу ерөнхийг танин баригч дотоод мэдрэхүй болсон сэтгэл хэмээх нэгэн дхарма. Түүнээс үүдэгч сэрэхүй, сэтгэхүй, хуран мэдэхүй, бишрэл, самади, мунхаг, сэрэмжгүй, зальхай, хуурмаг, харам ... тэргүүтэн сэтгэлийн тодорхой төлөвийг үзүүлэгч дхарма нийт 46 дхарма бүгд 47 байна. Бие махбодь ба оюун санаа, бие ба сэтгэлийн хоорондын харилцааг сэтгэл лүгээ адил төгөлдөр бусын 14 дхарма илэрхийлж, тэдгээрийн аль алианаа нэвтчин ерөнхий нөхцөл нь болж, тэднийг танин

³⁰ Монгол улаан шунхан Данжуур, Х.292, дээд.

барьж, сэтгэлээрээ тэдгээрт уусан шингэх боломжийг хуран эс үүдсэн хэмээх 3 дхарма илэрхийлнэ”³¹ гэж тайлбарлажээ.

Дээр дурьдсан “75 дхармыг оршихуйг шүтэн барилдуулагч 5 цогц, 12 төрөн түгэхүй, 18 язгуур болгож ангилдаг. Таван цогц нь дүрсийн цогц (rupa), сэрэхүйн цогц (vedana), хуран мэдэхүйн цогц (sanna), хуран үйлдэхүйн (sankhara) болон тийн мэдэхүйн цогц(vinnana) мөн. Арван хоёр төрөн түгэхүй нь нүд хийгээд түүний оногдохуун дүрс, чих хийгээд түүний оногдохуун дуу тэргүүтэн арван төрөн түгэхүйн дээр сэтгэлийн төрөн түгэхүй түүний оногдохуун болсон номын төрөн түгэхүйг нэмж нийт 12 болно. Энэ нь мэдрэхүйн ертөнцийн төрөн түгэх үндсэн төлөв, төрөл хэлбэрүүд юм. Танин мэдэхүй нь шүтээн, шүтэгчийн ялгал буюу язгуур эрхтэн эдлэл (veshai) энэ хоёрын барилдлага болсон тийн мэдэхүй гурвын уялдаа болох тул нийт 18 язгуур гарах ажээ. Таван цогц нь хуран үүдсэний 72 дхармыг хамрах хийгээд номын төрөн түгэхүй, номын язгуур хоёрт хуран эс үүдсэн 3 дхарма ч бас хамрагдана. Чингэвэл, 12 төрөн түгэхүй, 18 язгуур нь нийт 75 дхармыг бүхэлд нь хамарсан ангилал болой”³².

Орчлонгийн бүхэллэг чанарыг таньж мэдэх оролдлого, тайлал нь манай уламжлалт сэтгэлгээнд хүн байгаль хоёрын барилдлага, байгалийг ойлгох нь хүний гэгээрлийн суурь үндэс мөн гэх натурфилософийн үзлээс³³ эхтэй байсан. Монгол сэтгэлгээ, соёлын салиггүй бүрэлдүүн болж нэгэнт хэвисэн Буддын философийн бэлгэ чанар ертөнц бүхэлдээ хүнээс шалтгаалан нөхцөлдөж, шүтэн барилдаж байдаг, бүх оршигч, түүний дотор хүн өөрөө байнга эрч хүчтэй өөрчлөгдөгч (анитья) шинж чанартай гэж баталдагт оршино. Будда брахманы философи шиг хүн бие ба огт хувирдаггүй сүнс (анатма-вада) хоёроос тогтдог гэж үзээгүй, харин бие болон оюун санааны мэдэгдэхүүнийг бүрэлдүүлж, мөхөөж байдаг дхармуудын таван бүлэг махбод(скандх)-оос тогтдог гэж сургасан билээ. Гэхдээ энэхүү түгээмэл өөрчлөгдөгч чанартай дхармууд шүтэн барилдаж үүсэх хууль(пратитья-самутпада)-д захирагдах тул эмхгүй буюу хаос биш юм. Дхарма буюу дээд номын хуулиар тусгай нэг юм үүсэх шалтгаан нь өөр нэг юм үүсэх үрийг ямагт агуулж байдаг. Шалтгаан

³¹ Васубанду. Ил номын санг номлогч. II бүлэг (орон). //Монгол Данжуур, 151дүгээр боть. X. 81дээд, X. 112 дээд.

³² Васубанду. Ил номын санг номлогч. II бүлэг (орон). //Монгол Данжуур, 151дүгээр боть. X. 39. Дээд, X. 81 доорд

³³ Өлзий Тү. Эртний монголчуудын экологийн соёл сэтгэхүй. Хөх хот, Багшийн их сургуулийн хэвлэл. Худам бичгээр. 2010. X. 26-38

буйн учир үр гарах тул шалтгаангүй урсгалаар үүсэх юм үгүй. Орчлонгийн жам ёсны өөрчлөлтийн түгээмэл хууль, хөдлөнги төлөвийн талаарх энэ баримтлал оршихуйн өөрчлөгдөгч зүй тогтол, хоосон чанарыг тайлах түлхүүр болох амуй. Оршихуйн бүх төлөв, арга хэрэгсэл хоосон чанар боловч дхарма буюу дээд хуулийг танин мэдсэнээр үнэнд хүрч чадна. Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтол шүтэн барилдахуйг монгол орныхоо газар нутаг, хүн ардын амьдрах ухаан, тодорхой шинжлэх ухаануудын онцлогт тохируулан хянан засварлаж редукци, математик, астрофизик, космологийн ололт амжилтыг философитой холбон бүтээлээ туурвиж байсан эрдэмт лам Судар бичгийн хүрээлэнгийн зөвлөх, жинхэнэ гишүүн, тооны ухааны аймгийн дарга гоман дооромбо Ц. Гэлэгжамц байсан. Тэрбээр “нангиад ёсны шар гэгдэх одон зурхайн “Солбицон барих бодрол бичиг”, үйлийн зурхайн ёсоор нарны байрлалыг 5565 хоногт давтагдах дүрмийг мөнхөд түргэн бодох аргыг боловсруулжээ. Ийм бүтээл Нангиад, Төвд, Энэтхэгт эдүгээ хүртэл гараагүй бөлгөө”³⁴. Энэ нь зөвхөн астрофизикт төдийгүй космологи, философийн метафизикт оруулсан хувь нэмэр болсон гэж үзэж болно.

Гурав. Орчлонгийн шүтэн барилдах журмын танин мэдэх ёсны үндэслэл (The Epistemological Foundation for a Harmonized Universe Order).

Танин мэдэхүйн ерөнхий асуудлыг судалдаг философийн салбарыг **гносеологи** гэдэг бөгөөд түүний дотор шинжлэх ухааны танин мэдэхүйг тайлбарладаг гол хэсэг нь **эпистемологи** буюу шинжлэх ухааны танин мэдэхүй мөн. Эпистемологи нь шинжлэх ухааны мэдлэгийн шинж чанар болон итгэл үнэмшлийн үндэслэл, ухаалаг байдлыг судалдаг. Танин мэдэх ёсны төвт (1) мэдлэгийн шинж чанарын философийн задлан шинжилгээ, үнэн хийгээд зөв мэдлэг, итгэл үнэмшлийн хэлхээ холбооны тухай асуудлууд, (2) танин мэдэж үл болох тухай янз бүрийн асуудал, (3) мэдлэгийн эх сурвалж ба үндэслэлтэй итгэл үнэмшлийн хэмжээ, (4) мэдлэгийн шалгуур ба үндэслэлүүдийг судлах явдал оршдог .

Хамгийн зүй зохицолт, шүтэн барилдсан Орчлонгийн жам ёсны хуулийн шинжлэх ухааны танин мэдэхүй (Epistemology for a Harmonized Universe Order). Үнэн мэдлэгийг зөвхөн ухаанаар л олж авч болно гэдэг өрнөдийн рационализм бүх оршигчийн

³⁴ Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Гэлэгжамц дооромбо. Эмхэтгэн найруулсан Д. Цэрэнсодном. УБ., 2017. Х. 28

үндэс нь нэг л эхлэл байдаг гэж хязгааргүй итгэдэг ерөнхий үзэл баримтлалдаа баригдан мухардалд орж, юм үзэгдлийг шулуун шугамын нэг хэмжээст түвшинд авч үзэх хүртлээ алдран доройтжээ. Энэ хязгаарлагдмал үзэл баримтлал нь нэг талаас, бүх оршигчийн эхлэл нь бодит зүйл, бодис байх ёстой гэж үздэг материализм, эсвэл тийм эхлэл нь санаа байна гэдэг идеализмд хүргэж, тэд нь философийн бусад бүх тайллыг үл тэвчих, улиг болсон хатуу байр сууриар хязгаарлагдах болсон юм. Философийн ийм арга зүйн үүднээс бүхний эхлэл, ертөнцийн суурийн анхны “тоосго”-ыг олж авах гэсэн оролдлого 2500 жилийн өмнөөс эхлэн одоо ч үргэлжилсээр байна.

Өрнөдийн шинжлэх ухааны танин мэдэхүй 2500 гаруй жилийн турш хөгжихдөө XIX зууны эцэс хүртэл ухамсар, сэтгэлгээний бодит ертөнцөд нэвтрэн орж чадаагүй бөгөөд танин мэдэхүй болоод мэдрэхүйн тухай түүний үндсэн ойлголтууд ноцтой дутагдалтай явж иржээ. Үнэн мэдлэгийг зөвхөн ухаанаар л олж авч болно гэж хэтийдсэн өрнөдийн рационализмын танин мэдэхүйн онолуудад ухамсаргүй ба хүртэхүй хоёрын, бие махбодийн бүтэц болон үйлдлийн хэв маяг хоорондын салшгүй холбоог огт задлан шинжилдэггүй байв. Харин XX зууны эхээр харьцангуйн онол, квант механик, генетикийн ололт, сэтгэцийн задлан шинжилгээ зэрэгт гарсан хувьсгал, шинжлэх ухааны хөгжлийн өөртэйгөө зөрчилдсөн, иррационал гэгдэх шинэ нээлтүүд өрнөдийн философийн онтологи болон эпистемологийг мухардалд оруулан “философи сөнөлөө” гэж үзэхэд ч хүрч байв. Орчлонгийн зохион байгуулалтын үндсэн зүй тогтлыг тайлбарлах ийм баримтлал марксист материализмын үед философи дахь ангийн тэмцэл болж хувирсан билээ. Олон ургалч үзлийг бүгд хүлээн зөвшөөрсөн өнөө үед ч зөвхөн ухааныг шүтэж, шинжлэх ухааныг хэт объективчилсон философидоо баригдсан өрнөдийн соёл сэтгэлгээ даяаршлалаар дамжуулан өөр соёл, өөр сэтгэлгээг үгүйсгэх, дарангуйлах, устгах оролдлого гаргасаар байна. Үүнийг сөрөн зогсож, шинжлэх ухааны танин мэдэхүйн шинэ онол хүргэх арга зүйг тайлал зүйн мэдэгдэхүүний билиг гарган өгч чадна.

Буддын философи хоосон чанарын категорийг ашиглан Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтол, суурь үндсийг тайлбарладаг олон онол сургаалаас аль нэгийг хэтийлгэн баримтлагч өрөөсгөл үзэл, сэтгэлгээнээс ангижран танин мэдэхүүд төв замын мөрийг баримталснаар дөрвөн их үнэнд хүрнэ гэдэг. Энэ дөрвөн их үнэн нь: зовлонгийн үнэн, шалтгааны үнэн, гэтлэхүйн үнэн ба мөрийн үнэн болой. Мөн түүнчлэн үнэн тус

бүрийн бэлгэ чанар болох суурь, үнэн тус бүрийн гүйцэтгэх үүрэг буюу мөр, үнэн тус бүрийн хүрэх үр дүн буюу үр хэмээх гурван үндсийг гаргажээ.

Танин мэдэхүйн харьцуулсан онол (Comparative theory of epistemology). Танин мэдэхүйн ёсонд эргэлт гаргахын тулд орчин үеийн шинжлэх ухаанч философийнхон феномэнологийг ашиглаж, философийн шинжлэх ухаан гэж байх л юм бол тэр нь феномэнологи мөн гэдэг. Феномэнологи (монг. мэдэгдэхүүн, герм. *phenomen*, анг. *phenomenon*, хятадаар 現象 *xianxiang*) бол шинжлэх ухаанч философи бөгөөд шинжлэх ухааны судалгааны аргад хамаарахгүй бүх зүйлээс философийг цэвэрлэснээр танин мэдэхүйн ерөнхий онолд эргэлт болж чадах ажээ. Ийм философи монголын буддизмд бий тул түүнийг орчин үеийн феномэнологитой харьцуулан шинжлэх нь зүйтэй. Феномэнологийн *epoche* бол гол төлөв тодорхой таамаглалд хамаарах өмнө мэдэж байсан бүх зүйлээс татгалзан, юмны оршин тогтнох байдал, түүний түүхэн давхар утга, учир шалтгааны тогтолцоонд эзлэх байр суурь гэх мэтийг түр зогсоон юмыг өөрийг нь ухамсарлах зарчим билээ. Эпохег хэрэгжүүлэх, мэдэгдэхүүний тухай үзэл санаанаас татгалзах, хоосон чанарын хаах зарчим үйлчлэх оюун ухааны дотоод эрч хүчний тэгш хэмт харилцааг харьцуулан шинжилснээр бид танин мэдэхүйн ёсонд нэг шинэ алхам нэмж энэ хоёр үйл явц зүгээр эргэн нийлж нэгддэг биш харин шүтэн барилдаж мэдэгдэхүүний өөрөө тодрох гоц чанарыг харуулж, хоосон чанарт хүрэх трансценденталь эргүүлэн хянан засварлах, тайлал зүйн илүү гүн тойрог болдог гэсэн дүгнэлтэнд хүрнэ. Хоосон чанарын тухай монголын хэтрүүлэгч төв үзлийн сургаал шинжлэх ухааны танин мэдэхүйд илүү дөхөмтэй арга зүйтэй. Хоосон чанарыг танин барихуйд ойртон дөхөж очих ойлголт эдүгээгийн шалгадаг ухаанд олон буй нь “сингуляр чанар”, нягтран хатуурах(скляр “skleros”) орон ба боломжит бөөмсийн квантын хоосон байдал(вакуум) зэрэг амой. Физикийн шинжлэх ухааны судлаж үл чадахын хаяалбар болох сингуляр(латин хэлний *singularis* –цорын ганц гэсэн утгатай үг) чанар, юм, үйл явдал болон үзэгдэл өөртөө нягтран орон, хугацаагүй нэгж болох чанар буюу материйн биет нягтрал эцэс төгсгөлгүй нэгдмэл болох тухай маш нарийн төвөгтэй, хүнд бэрх бөгөөд одоохондоо физикчид, космологичдын аль алин нь нэг мөр болгон тайлбарлаж чадахгүй байгаа бодотын чинад

анхдагч үндсийн утга, түүний орших тэг орон³⁵, хугацаа зогсох агшинг тэмдэглэдэг философийн категори болох хоосон чанарт дөхөж очих ойлголт мөн.

Харьцангуйн ерөнхий онолыг ухраан хэрэглэснээр ийм үзэгдэл үүсэх учиртайг хатуу баталсан Хоокинг “сингуляр чанар бүтэх эхлэлийн агшин бидний мэдэх физикийн нэг ч хуулинд захирагдахгүй бөгөөд хязгааргүй нягтралын үед хаосын хэмжээс тэг рүү тэмүүлэх учир материйн нягтрал ба температур нэгэн зэрэг хязгааргүй байж чадахгүй” гэж үзэж байсан нь сингуляр чанар ба скляр орон бол хоосон чанараас өөр боловч харьцуулж болохыг харуулах шинжлэх ухааны үндэслэл болой. Мөн түүнчлэн “хоосон сингуляр чанар” (англи хэлээр *Naked singularity*) гэсэн ойлголт ч бас буй. Энэ нь өнгөрсөн үеийн нэг агшинд материйн эрчмийн нягтрал ба орон болон хугацааны муруйлт физикийн хувьд маш өндөр, математикийн үүднээс хязгааргүй байх төлөв байдлыг илэрхийлдэг. Чингэж харьцуулснаар бид сингуляр чанарын орчимд орон ба хугацааны хувьслын харьцангуйн ерөнхий онолын суурь асуудлыг шийдэх ирээдүй, хоосон сингуляр чанар байгальд байх боломжтойг гаргаж өгөх философийн үндэслэлтэй болох амой.

Танин мэдэхүйн төвшинг ялган түүнд сэтгэхүйн эзлэх байр суурийг “Данжуур” –т заахдаа “бусдын тусын тулд үнэхээр Будда болох (гэгээрэхүй) нь болой”³⁶ хэмээгээд түүнд хүрэх аргыг 22 сэтгэлээр нарийвчлан гаргажээ. Тухайлбал, их сан, эрдэнэ гарахын орон, их далай, очир, уул, эм, буяны садан, чандмань, наран, дуулал мэт сэтгэлээр арван барамид буюу чинад хязгаар хүрэх тогтолцоо болох өглөг, шагшабад, хүлчингүй, хичээнгүй, диян, билэг, мэргэн аргын, ерөөлийн, хүчний, бэлгэ билгийн сэтгэл тус тус үүсэх нарийн арга замыг тодорхойлсон байна. Энэ бүхнийг дамжсанаар сэтгэлийн гэм хор алдарч, сэтгэл нэгэн үзүүрт зангилагдан бодь сэтгэл буюу өршөөнгүй өгөөмөр сэтгэлд хүрч, улмаар чанад мэдлэгт хүрэх арга хуримтлагддаг ажгуу. Жишээлбэл, хөлөг мэт сэтгэл үүсэх нь амарлингуй ахуй, үлэмж үзэхүй сэтгэлийн төвшинд хүрч мэдлэг үүснэ гэх мэт. Сэтгэл үүсэхийн эцсийн зорилгыг “Данжуур”-т “Сэтгэл үүсэх хэмээхийн учир нь тийн мэдэл лүгээ тийнхүү ухагч болой, тийн мэдэл алин буй хэмээвээс сэтгэлийн тийн мэдэл бөгөөд цагааны хамаг ном дор зорих нь түүн дор болохын тул болой”³⁷ гэжээ.

Танин мэдэхүйн хаалт ба эпохе. Буддын философийн хоосон чанарт хүрэх хаалт ба феномэнологи дахь эпохе хоёрыг харьцуулан шинжилсэн Ж. Гарфийльд “...эрохе бол гол

³⁵ Andrei Linde. Inflationary multiverse and eternal chaotic inflation. Stanford. 2008. P. 82-88

³⁶ Монгол улаан шунхан Данжуур, 1. 89 боть, 22 дээд.

³⁷ Монгол улаан шунхан Данжуур, 1. 89 боть, 36 дээд.

төлөв тодорхой таамаглал хэлбэртэй байдаг тусагдахууны тухай бүх мэдлэгээс татгалзах, түүний оршихуйн төлөв байдал, түүхэн давхар утга, учир шалтгааны тогтолцоонд эзлэх байр суурь гэх мэтийг үл зөвшөөрөх үйлдэл болохын хувьд хоосон чанарт хүрэх хаалтуудтай төстэй”³⁸ гэж тодорхойлжээ. Энэ нь хэтрүүлэгч төв үзлийн хаагдахуун ба “дөрвөн хязгаараас төрөхийг хаах ухаан” лугаа адил бөгөөд эдгээр нь (а) “өөрөөс төрөхийг”, (б) “бусдаас төрөхийг”, (в) “хоёулангаас нь төрөхийг”, (г) “шалтгаангүйгээс төрөх”-ийг хаах явдал мөн. Мадхьямака философийг тусгайлан судалсан академич Г. Лувсанцэрэн агсан “...хоосон чанарын категори нь оршин буй бүхний үндсэнд байгаа түгээмэл чанарыг үнэмлэхүй хийгээд харьцангуйн нэгдэлд илэрхийлж, нэг талаас абсолют, нөгөө талаас релятив шинжтэй, тэдгээрийн нэгдэл болсон ойлголт юм”³⁹ гэж тодорхойлжээ. Тэр энэ санаагаа цааш гүнзгийрүүлэн “уг нь хоосон чанарыг үгээр илэрхийлэхийн аргагүй бөгөөд түүнийг өгүүлэхэд хэл зогсох билээ. Түүнийг онон барих гол нэгэн арга бол бясалгал юм” гэжээ. Энэ нь хэтрүүлэгч төв үзлийн нийт 64 хаагдахуун, түүний дотор “Би-үгүй”-н 10 хаагдахуун ба “дөрвөн хязгаараас төрөхийг хаах ухаан” лугаа адил бөгөөд сүүлийн дөрөв нь (а) “өөрөөс төрөхийг”, (б) “бусдаас төрөхийг”, (в) “хоёулангаас нь төрөхийг”, (г) “шалтгаангүйгээс төрөх”-ийг хаах явдал мөн. Феномэнологийн *epoche* бол гол төлөв тодорхой таамаглалд хамаарч буй өмнө мэдэж байсан зүйл бүхнээс, өөрөөр хэлбэл юмны оршин тогтнох байдал, түүний түүхэн давхар утга, учир шалтгааны тогтолцоонд эзлэх байр суурь гэх мэтийг түр зогсоон ухамсарлах зарчим билээ. Харин бид феномэнологийн эпохег хэрэгжүүлэх, татгалзах үйл, хоосон чанарын хаах зарчим үйлчлэх оюун ухааны дотоод эрч хүчний тэгш хэмт харилцааг харьцуулан шинжилснээр бид цааш танин мэдэхүйн нэг алхам нэмж энэ хоёр үйл явц зүгээр эргэн нийлж нэгддэг биш харин шүтэн барилдаж мэдэгдэхүүний өөрөө тодрох гоц чанарыг харуулж, хоосон чанарт хүрэх трансценденталь редукци, тайлал зүйн илүү гүн хүрд болдог гэсэн дүгнэлтэнд хүрсэн.


Орчлонгийн Их Тэлэлт ба Их Агшилтыг хам ойлгон Риманы хаалттай ертөнцийн загварыг философийн үүднээс тайлбарлавал: Орчлонгийн эхлэл, төгсгөл болсон сингуляр чанар нь коллапс (сулралт, уналт) ба реколлапсын (сэргэлт) нэгдэл амой. Үүнд коллапс (уналт) нь сүйрлын шинжтэй таталцлын агшилт буюу Их түрдэл, реколлапс (сэргэлт) нь орчлонгийн хягааргүй тэлэлт буюу Их тэсрэлт болно. Зарим эрдэмтэд сингуляр чанарын

³⁸ Garfield, J., “Epoché and śūnyata: Scepticism East and West,” *Philosophy East and West*, 40: 3: 1990. P. 288.

³⁹ Г. Лувсанцэрэн. Төв үзлийн философийн онолын үндэс. УБ., 2006. Х. 134-135.

төлөв байдалд орон ба хугацаа бүрмөсөн алга болдог гэх атал зарим нь тэнд орон ба хугацаа нь үл баригдах, хязгааргүй гажсан, үл гэрэлтэх хоосон чанар болж хувиран оршдог гэж үздэг.

Дүрслэл 1. Феномэнологийн эпохе ба мэдэгдэхүүний билгийн хаагдахуун хоёрыг харьцуулан шинжлэхүй



Тухайлбал, Ж. Уилер "Уилер Д. Предвидение Эйнштейна. М.: Мир, 1970. С. 56." үйл явдал үл орших, орон ба хугацааны, шалтгаан ба үр дагаварын дараалалд орших ч аргагүй, хөөсөнцөр маягийн"⁴⁰

⁴⁰ Уилер Дж. Предвидение Эйнштейна. М.: Мир, 1970. С. 56.

хэмээн тодорхойлсон байдаг. Далай лам ч хоосон чанарын сургаалыг орчин үеийн космологи ба физикийн шинжлэх ухааны сингуляр чанарын онолтой холбон орчлонгийн эхлэл, төгсгөлийг хязгааргүй төрөх, түрдэхүйн шүтэн барилдлагаар тайлбарлаж байна⁴¹. Манай нэрт эрдэмтэн академич Ш. Лувсанвандан багш төв үзлийн “хоосон чанар” гэдэг ухагдахууныг задлан шинжлээд энэ нь “орон ба хугацааны харьцааны үгүйсгэл юм”⁴² гэсэн дүгнэлтэнд хүрсэн билээ. Түүнийхээр хоосон чанар гэдэг нь юмны эрх тэгш шүтэн барилдсан өөрийн чанарыг олж, юмыг бүхэл болгож харах үзэл, арга ажээ. Энэ бүхэнд дулдуйдан үзэхүл, “хоосон чанар” хэмээх категори оршин буй бүх юмс, түүний дотор орон ба хугацаа, шалтгаан үр зэрэг бүгд үүсэн гардаг төгс төгөлдөр хаос буюу шинжлэх ухааны хэлээр сингуляр чанарын чинад дахь материаллаг, сүнслэг, оюунлаг оронг тэмдэглэж буй нь нотлогдох авай. Дорнын сэтгэлгээ энэ ерөнхий утгыг их дээр үеэс мэддэг байсан ажээ. Христийн тооллын өмнөх VI зуунд хятадын агуу сэтгэгч Лаозы эхлээд юу ч байгаагүй, тэнгэр ч, тэнгэрийн доорхи ертөнц ч, Газар ч, Нар ч, орон ч, хугацаа ч, дэг журам ч, эмх замбараагүй ч байгаагүй, Бурхан ч байгаагүй. Зөвхөн Дао л байсан: оршигч бүхэн бүгд Даогаас үүсч, ахуйгаа бүтээсний эцэст Даод буцаж ордог хэмээн сургажээ⁴³. Эндээс үзвэл, Дао бол буддын философийнхоор хоосон чанар, бүрэн төгс хоосон, нэрийдэлгүй чанар, эдүгээгийн шинжлэх ухааны ойлголтоор сингуляр чанарт хүрэх танин мэдэхүйн зам ч байж болох амой.

Танин мэдэхүйн хязгаарлагдмал чанар. Алив тогтолцооны дотроос бүрэн төгс мэдлэг гарч чадахгүй тухай Курт Геодл (Gödel)-ийн онол математик логик төдийгүй математикийн философийн үндэс болдог. Түүний гаргасан теорем (Gödel's incompleteness theorems) нь бүх математикийн хувьд бүрэн төгс, зөрчилгүй цуглуулгыг олж болно гэдэг Гильбертийн хөтөлбөр боломжгүй гэдгийг харуулсан. Формаль тогтолцоонуудын хязгаарлагдмал шинжийн тухай хоорондоо нягт холбоотой хэдэн баталгаануудын эхнийх нь диагональ үндэслэлийг ашиглан бүрэн бус мэдлэгийн тухай санааг гаргасан Геодлийн теоремууд байсан юм. Түүний араас үнэний формаль тодорхойгүй чанарын тухай Тарскийн теорем, Гильбертийн Entscheidungsproblem

⁴¹ Dalai Lama (2005). *The Universe in a Single Atom: The Convergence of Science and Spirituality* (Hardcover). Broadway.

⁴² Ш.Лувсанвандан. Мадхьямака хэмээх дундад үзэл.-Философи эрхийн судлал. 1 боть. УБ., 1970. Х. 88

⁴³ Лаоз-ын гүн ухаан. УБ., 2014. Х. 18, 20, 32,42

бодлого шийдвэрлэгдэх боломжгүй гэдгийг баталсан Черчийн нотолгоо ба танин мэдэхүй зогсох асуудлыг шийдвэрлэх алгоритм байхгүйг баталсан Тюрингийн теорем тус тус гарсан. Энэ бүхэн хүний танин мэдэхүйн хязгаарлагдмал тал, Орчлонгийн жам ёсны зүй тогтлын тухай бүрэн төгс үнэн мэдлэгийг бид дотроос нь гаргаж чадахгүй тул үнэмлэхүй үнэнд байнга тэмүүлэх философийн тайлал зүйн мэдэгдэхүүний билгийн хаалтын тухай үзэл санаатай адил байна. Энэ тухайд З. Агваанбалдан вээр “Янагуух үнэнийг ялгаваас, бусдын эрхт ба хотол нэрийтгэл хоёр. Дуун өгүүлэхүйгээр нэрийтгэлийн янагуух, мэдлийн янагуух, өгүүлэхүйн янагуух гурав. Бусдын эрхтэд хутагтын тэгш агуулсан тийн үл адхаглах бэлгэ билиг мэт арилсан бусдын эрхт, зовлонгийн үнэн, бүхэн гарахуй үнэн хоёр мэт эс арилсан бусдын эрхт хоёр ба дэлгэрэнгүй ялгаваас арван таван тийн ухахуй буй бөлгөө”⁴⁴ хэмээсэн байна. Тэгэхлээр “танин мэдэх чадвар хязгаарлагдмал, зохистой байрлуулах, хянан засварлах технологи дутагдалтайгаас болж хүний үйл ажиллагааны үр дүн ямагт алдаа гаргах боломжтой тул ертөнцийг бүхэлд нь бүрэн төгс ойлгож хэзээ ч чаддаггүй”⁴⁵ гэж дүгнэж буй философич эрдэмтэдтэй санал нийлэхээс өөр аргагүй.

Философийн харьцуулсан судалгаа хийх үед, ялангуяа эртний дорно дахины сэтгэлгээний уламжлалыг эш сурвалж болгохдоо тухайн цаг үеийнхээ тусгал болж үзэл сурталжсан, шашны сурталд баригдсан тайлбаруудыг үл огоорон гагцхүү баримт нотолгоонд үндэслэж хандах зарчим баримталах нь чухал. Бас философи нь юм, үзэгдлийн чинад түгээмэл зүй тогтлыг судалдаг гэж тунхагладаг атал судалгаандаа зөвхөн өрнөдийн эх сурвалжийг ашиглах нь шинжлэх ухаанч байх зарчимд харшлах болно. Орчлонгийн түгээмэл зүй тогтлыг тайлбарлах философи метафизик космологи, эгэл бөөмсийн физик ба астрофизик буюу од гарагийн бодис зүйн, байгалийн шинжлэлийн болон хүмүүнлэгийн мэдлэг, хүн төрөлхтний хуримтлуулсан соёл сэтгэлгээний бүх л өвд тулгуурлан янагуух үнэнээс үнэмлэхүй үнэнд чиглэн хөгжинө.

Дөрөв. Орчлонгийн жам ёсны хөгжилд шинжлэх ухаан, технологийн үүрэг

⁴⁴ Агваанбалдан З. Хаврын охин тэнгэрийн дуулал нэрт... УБ., 2017. Х. 100

⁴⁵ Jьrgen H. Franz. Nachhaltigkeit, Menschlichkeit, Scheinheiligkeit. Philosophische Reflexionen ьber nachhaltige Entwicklung. Мьnchen 2014

Шинжлэх ухаан ба хөгжил. Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтлын философийн арга зүйгээр задлан шинжилж, зөв тайлбарлах нь тогтвортой ирээдүйн ашиг сонирхлын үүднээс шинжлэх ухаан, технологи ба инновацийг ашиглах онолын үндэслэл болж өгөх төдийгүй, алсын хараатай бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хөтөч болох практик ач холбогдолтой амой. Энэ асуудлыг дэвшүүлэхэд олон нийтийн ухамсар, тэр бүү хэл шинжлэх ухааны эргэлтэнд ч нэг хам болж хэрэглэгдэх нь их болсон “шинжлэх ухаан”, “технологи” гэдэг хоёр ойлголтыг ялгаж үзэх нь чухал. Шинжлэх ухаан байгалийн шинжлэлийн юм үзэгдлийг судалдаг тул тодорхой байр суурьтай мэдлэг, байгалийн хууль зүй тогтлыг нээх явдал байдаг бол технологиуд хавсарга шинжлэх ухаан ба инжинирингийн үр дагавар, прескриптив мэдлэг буюу байгалийн хууль зүй тогтол, материал баялгийг бүтээхийн тулд мэдлэгийг зөв байрлуулах чадвар юм. Орчлонгийн тухай шинжлэх ухааны мэдлэг, технологийн ойлголт хүн төрөлхтөнд эдийн засаг, нийгэм хүмүүнлэгийн болон экологийн шинж чанартай тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хүн болон байгалийг энэрэхтэй шүтэн барилдсан тогтвортой хөгжлийг хангах боломж олгоно.

Чухамдаа технологийн үндэс нь ихэнх тохиолдолд суурь шинжлэх ухаанууд байдаг бөгөөд хөгжлөөр буурай орнуудад ч гэсэн гаднын технологийг өөриймшүүлэхийн тулд мэдлэг ба үзэл санааг хадгалах ба шинжээчийн төв болсон шинжлэх ухааны судалгааны бааз зайлшгүй хэрэгтэй. “Шинжлэх ухаан” хэмээх ойлголтын утгыг өрнөдийн эрдэмтэд латин хэлний “scientia” буюу “мэдлэгийн агуулга, ач холбогдол” гэдэг үгнээс гаралтай гэж үздэг. Шинжлэх ухаан нь мэдлэгийг эрэн хайх аль ч салбарт байлаа гэсэн “шинжлэх ухааны арга”-ыг хэрэглэн олж авсан мэдлэгийн зохион байгуулалттай, тогтолцоот нийлбэр цогцод хамаарна. Шинжлэх ухаан нь байгалийн шинжлэл ба нийгмийн ухаан гэсэн хоёр хамгийн өргөн ай салбарт хамаарах бүлгээ.

Байгалийн шинжлэлд гэрэл сүүдэр гэх мэтийн янз бүрийн объектууд, асуулт, газар, тэнгэр болон хүний бие гэх мэтийн байгалийн тусагдахуун, юм, үзэгдлийн тухай шинжлэх ухаанууд багтана. Байгалийн шинжлэх ухааныг цааш нь бодисын тухай, газар дэлхийн тухай, амьдралын болон бусад зүйлсийн тухай шинжлэх ухаан гэж задлан ангилдаг. Бодисын зүй нь физик (физик тусагдахуунуудын тухай шинжлэх ухаан), хими (бодисын хувирал янз бүрийн урвалын тухай шинжлэх ухаан), и астрономи (огторгуйн тусагдахуун биетийн тухай шинжлэх ухаан) зэрэг салбар ухаан болгон задалж үздэг. Дэлхийн тухай

шинжлэх ухаан нь геологи (газрын хөрсний тухай салбар ухаанууд) болж хуваагддаг. Амьдралын тухай шинжлэх ухаан биологи (бие махбодийн тухай шинжлэх ухаан) ба ботаник (ургамалын тухай ухаан)-ийн салбар ухаан гэж ангилагддаг.

Байгаль дэлхийгээ сүйтгэн нөөц баялгийг нь бараад өөрсдөө мөхөхийн ирмэгт ирсэн энэ заагт хүн төрөлхтөнд оюун санаагаа өөрчлөн засварлаж, амьдрах ухаан, хүмүүнлэгийн ухаан ба шинжлэх ухааны мэдлэгийн шүтэн барилдсан агуу их ач холбогдлыг эргэцүүлэн ойлгосны үндсэн дээр шинжлэх ухааны үзэл санаа ба ёс журам, зан аалийн эрхэм сайн, шударга зарчмуудыг удирдлага болгон тогтвортой амьдрахаас өөр зам үлдсэнгүй. Үүний тулд хөгжлийн бодлого төлөвлөгөөнийхөө суурь үндсэн шалгуур болгон эдийн засаг, нийгэм, улс төрийн үзүүлэлтүүдийг авч үзэх бус харин хүн бүрийн хөгжлийн, үндэстэн бүхний байгалийн соёл, даруу төлөв сэтгэлгээний өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх асуудлыг тавих нь чухал. Манай ард түмний сэтгэлгээний уламжлалд **“Хөнжлийнхөө хэрээр хөлөө жий”** гэдэг философийн сайхан өв бий.

Шинэ зууны технологи (“Ge-stell”) буюу урлах ухааны зохистой байрлуулан тавих, төгөлдөршүүлэх мэдлэг аж үйлдвэр гэхээс илүүтэй хувь хүн рүү, түүний хөгжилд чиглэж эхэллээ. Энэ үйл явц компьютерын хангамж, мэдээлэл технологийн салбарт нэн тэргүүнд ажиглагдаж байна. Хүний хөгжилд туслах, үйлдлийг хянан засварлах мэдлэг, чадвартай ухаалаг утас ба өгөгдлүүдийн хараат бус бааз болох **блокчейн (Blockchain) технологийг хөгжлийг хурдасгах хүчин зүйл болгон ашиглах болов. Үүний цаанаас хүн, нийгэм ба байгалийг шүтэн барилдахуйн жам ёсоор удирдах “хиймэл оюун ухаан”-ыг хөгжилд татан оролцуулах хамгийн түгээмэл зүй тогтлыг ойлгох, тайлбарлах философийн асуудал гарна.**

Хүний хөгжилд чиглэсэн төгөлдөршилт, урлах ухааны мэдлэг, арга хэрэгсэл хэдийн “тэжээх ухаан”-д нэвтрэн, бие махбодын хуучирч муудсан эд эрхтэнг “хуруун шилэнд” ургуулсан бэлэн нөөцөөс авч сольж ашиглах боломж олгох шинэ технологи аль хэдийн туршилтанд оржээ. 2006 онд японы биологич Синъя Яманака удам зүйн нарийн төвөгтэй эргүүлэг хийн хянан засварлах замаар эсийн цаг үеийг бүтэн эргүүлж, нэгэнт ялгарч тогтсон эсийг чөмөгний эсийн төлөв байдалд буцааж чадсан бөгөөд үүгээрээ нобелийн шагнал хүртсэн билээ. Цаашилбал, аранз шиг аппарат үүрээд л хүн дуртай зүгтээ чөлөөтэй хөөрөн нисэх боломжийг шинэ Зеландын Martin Jetpack компанийн инженерүүд туршиж байна. 2013 оны наймдугаар сард тэдний бүтээсэн «Prototip-12» гэдэг нэртэй нисдэг төхөөрөмж задгай орчинд чөлөөтэй нисэх туршилтын зөвшөөрлөө авсан юм. Ахмад настан болон

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг хэвийн болгож дэмжих, хүний бүх биеийн хөдөлгөөнийг хөнгөлөх хамгийн шилдэг технологи экзоскелет (exoskeleton)-иор японы Cyberdyne компанийн боловсруулсан бүрэн робот араг яс [HAL](#) тооцогдох болов. Зохистой байрлуулан тавьсан арга, мэдлэгийн ачаар хувь хүнд зөвхөн өөрт нь зориулагдсан эмийг хэрэглэх цаг ойртож байна. Манай уламжлалт эмнэлэгт хүний биеийн хий, шар, бадганыг оношлон ганцаарчлан хандаж зөвхөн өөрт нь зориулан эм найруулан өгдөг байсан мэдлэг, арга шинэ шатанд гарч хувь хүний удам зүйн онцлогт тохирсон ганцаарчилсан хандлага хэрэглэгдэж эхлэх боллоо. Түүгээр ч барахгүй хорь хорин таван жилийн дараа бүх өвчнөөс хамгаалдаг урьдчилан сэргийлэх тарилга ч бий болох төлөвтэй. Эрчим хүчийг хэмнэх, уламжлалт эх сурвалжуудыг зохистой байрлуулж тавьснаар асар их хямд өртөгтэй шинэ технологиудыг гарган авахаар туршиж байна. Голландын Dura Vermeer Group компани битүүмжилсэн (hermetic) төмөр бетон цул суурьтай, чиглүүлэгч овоолготой хөвдөг байшин барьж туршиж байгаа нь нам дор газрын оршин суугчдад хувьсгалт өөрчлөлт авчрах ирээдүйтэй. Үнэгүй эрчим хүч ашиглах технологид хувьсгал гарах төлөвтэй. Тээврийн асуудлыг шийдвэрлэхээр дирижабль буцаж ирлээ. Канадын Solar Ship компанийн төгөлдөржүүлэгчид нарны зайн хураагуураас цахилгаан эрчим хүч, хөнгөн хийн хөөрөх хүч, агаарын эрч хүчийг зохистой хольж ашигладаг (hybrid) дирижабль маягийн нисдэг аппаратын төсөл хэрэгжүүлж байна. Их үнэтэй төдийгүй улам бүр ховордож буй нефть бүтээгдэхүүнийг халах түлшний маш хямд эх сурвалж хийнгидрит(gas hydrate)-ийг ашиглах технологийг боловсруулж эхлэв. Энэ нь усны молекулаар “баглагдсан” метан хийн молекулууд юм. Нанотехнологийг аж үйлдвэрт ашиглаж, сансарт хүн болон ачаа тээшийг гаргах зардлыг хэмнэх төслүүдийн нэг болох сансрын өргүүрийн төсөл ч судлаачдын сонирхлыг татах болов. Ирээдүйд асар их хүчтэй пуужин, хэт дуу чимээ, дуунаас хурдлах, даралтын их ачаалал, олон үетэй зөөгч зэргийг умартан өргүүрт сууж, товчлуур дараад л сансарт аялах шинэ технологи эрэн хайж байна.

Энэтхэг, Төвд, Монгол гэх эртний номт гурван улсын хүрээнд буддын ёсны таван ухааныг ялгаж ирсэн нь, “**дотоод ухаан**” хэмээх шашны ухаан, “**дуун ухаан**” гэх хэл шинжлэлийн ухаан, “**тэмдэгт ухаан**” хэмээх философи, “**тэжээх ухаан**” гэх анагаах ухаан, “**урлах ухаан**” хэмээх зохион бүтээх ухаан болой. Эдгээрийг нэгтгэж, ерөнхий арга зүй болж байдаг нь тэмдэгт ухаан буюу философи амой.

Шинжлэх ухааны ерөнхий арга ба хандлагын өөрчлөлт. Ерөнхий арга хандлага нь философи болон тусгай шинжлэх ухаануудын онол-арга зүйн суурь үндэслэл хоёрын хоорондын завсрын чанартай арга зүй юм. Шинжлэх ухааны ерөнхий хандлага нь ХХ зуунд өргөн хөгжиж, одоо бол бүх салбарт ашиглагдах болжээ. Шинжлэх ухааны ерөнхий хандлагыг илэрхийлэх ухагдахуунд “мэдээлэл”, “загвар”, “бүтэц”, “үйл-ажиллагаа”, “тогтолцоо”, “элемент”, “магадлал”, “эмх замбараагүй байдал”, “төгөлдөршил”, “технологи”, “зохиол”, “шүтэн барилдахуй” гэх мэт ойлголтууд хамаарна.

Шинжлэх ухааны ерөнхий ухагдахууны тодорхойлох шинж нь нэгд, тэдний агуулгад философийн хууль, категори ба зарим тусгай ухааны ойлголт, онцгой чанар сүлэлдэн байдгаар илэрнэ. Хоёрт, тэдгээрийг хэлбэршүүлэн, тэмдэгт ухаан, учир зүйн болон математик онолын аргаар тодотгон харуулж болдогт бас оршино.

Философийн категориудын тусламжтайгаар бид ахуйн бүтэх арга нь хөдөлгөөн харин түүний орших хэлбэр нь орон ба хугацаа бөгөөд бүтцийн хувьд зохион байгуулагдсан ахуйн бүх төвшин өөрийн хөгжлийн явцад хамгийн түгээмэл хуулиудын үйлдлийг илэрхийлж байдаг гэдгийг мэдэх болно. Тэдгээрийг зөвхөн философийн зөв категориудын тусламжтайгаар л эргэцүүлж баймаажин танин мэдэж болох бүлгээ.

Философийн хууль, үндсэн айг илэрхийлдэг **матери, ухамсар, орон, хугацаа, сэтгэхүй ба шүтэн барилдахуй** зэрэг категори, судалгааны суурь хэрэглэгдэхүүнүүдийн утга шинжлэх ухаанчаар гүнзгийрч байна. **Нэгж, онцгой, хувь** хэмээх нь судлагдахууны объектийн тоон ба чанарын өвөрмөц тодорхой шинжид үндэслэн бусад ижил объектуудаас нь ялган түүний харьцангуй тусгаар байдал, өөрийн чанарыг илэрхийлдэг философийн категори бүлгээ. **Ерөнхий, түгээмэл** хэмээх нь бүх нэгж юм ба үзэгдэл, үйл явцын ахуйн зарчим болон бүхлийн бүрэлдэхүүн дэх тэдний хэлхээ холбооны зүй тогтолт хэлбэрийг илэрхийлдэг. **Мөн чанар ба үзэгдэл** бол ертөнц дэх ахуйн тодорхой чанар ба түүний танин мэдэхүйг **мэдэгдэхүүнээр** дамжуулан илэрхийлдэг. Мөн чанар нь судлагдахууны ахуйн хэлбэрийн олон янзын нэгдэл дэх объектийн дотоод агуулга болно. Үзэгдэл нь судлагдахууныг хэрэгжиж буй гадаад хэлбэрээр нь дамжуулсан илэрхийлэл. Мөн чанар, үзэгдэл хоёр шүтэн барилдаж, өөрөө тодрохыг **мэдэгдэхүүн** (phenomen) гэнэ.

Бүрдэл хэсэг ба бүтэц гэдэг нь судлагдаж буй объектийн нэгдлийг тэмдэглэдэг философийн категори бүлгээ. Бүрдэл нь бие биетэйгээ тодорхой харилцаанд орсноор

бүхлийг хангаж өгдөг нэгж элементүүд бол бүтэц бол тэдгээр элемент нэгдмэл нэг тогтолцоо систем болсны тогтвортой холбоо хэлхээний арга хэлбэр амуй. **Тогтолцоо буюу систем** нь харилцан хамааралтай хэлхээ холбооны үндсэн дээр бие биетэйгээ харилцан үйлчилж байдаг бүтцийн хувьд зохион байгуулагдсан элементүүдийн онцгой нэгдлийг илэрхийлдэг философийн категори мөн. **Шалтгаан ба үр** хэмээх нь судлагдаж буй объектийн хамааран нөхцөлдөх шинж чанарыг тэмдэглэдэг философийн категори болой. Үйлдэл нь үр дагавар хэмээх өөр үзэгдлийг араасаа дагуулж ирдэг үзэгдлийг шалтгаан гэдэг. **Зайлшгүй ба санамсаргүй** бол судлагдаж буй объектийн хэлхээ холбооны янз бүрийн төвшинг илэрхийлдэг философийн категори авай. Хэрэв зайлшгүй нь судлагдаж буй объектийн агуулгаар тодорхойлогдож байдаг хэлхээ холбооны зүй тогтолт шинжийг харуулдаг бол санамсаргүй нь гадаад, өөрчлөгдөж байдаг шалтгаанаар нөхцөлддөг хэлхээ холбооны хэв маягийг тэмдэглэдэг ажээ. **Боломж ба бодит байдал** нь судлагдаж буй объектийн үүсэл хөгжлийн хоёр гол үе шатыг тодорхойлж өгдөг философийн категори юм. Бодит байдал нь энд нэгж ахуйн бодот илрэл ахул боломж нь түүний дотоодод агуулагдаж байх авай. **Бүхэл ба хэсэг** гэдэг судлагдахууны бүхэл бүтэн чанар болон хуваагдаагүй бүхлийн тухай төсөөллөөс бүхлийг хэсэг болгон хуваадаг задлан шинжлэхүйд хүрч улмаар судлагдахууныг сэтгэлгээн дэх тодорхой бүхлийн хэлбэрт дахин төсөөлөх арга зүйн чиглэлийг тодорхойлдог философийн категори юм.

Философийн хууль, категориуд тусгай ба ерөнхийн харьцаа, түгээмэл нийтлэгийн хамгийн эцсийн боломжит зэргэмжийг илэрхийлж байдаг бол шинжлэх ухааны ерөнхий ойлголтууд хийсвэр-нийтлэг чанарыг хэлбэршсэн хийсвэр аргаар харуулж байдаг байна. Шинжлэх ухааны ерөнхий зарчмуудад системийн болон бүтэц-үйл ажиллагааны, магадлалын болон кибернетик, хэлбэршүүлэх болон загварчлах зарчмууд багтана. Сүүлийн үед синергетик гэх шинжлэх ухааны ерөнхий эрдэм онцгой идэвхитэй хөгжиж байна. Энэ бол байгаль, нийгэм ба танин мэдэхүйн салбар дахь ямар ч шинж чанартай байж болох нээлттэй тогтолцооны өөрийгөө зохион байгуулан, хөгжих тухай онол юм. Синергетикийн үндсэн ойлголтууд гэвэл “дэг журам”, “эмх замбараагүй”, “шугаман бус”, “тодорхойгүй”, “тогтвортой бус”, “бифуркац” гэх мэт. Эдгээр ойлголт нь “шүтэн барилдахуй”, “ахуй”, “хөгжил”, “бүрэлдэх”, “цаг хугацаа”, “бүхэл”, “санамсаргүй”, “боломж”, “тэмүүлэх чанар” зэрэг философийн ухагдахуунуудтай нягт холбоотой төдийгүй харилцан сүлэлдсэн байдалтай хэрэглэгдэх нь элбэг.

Шинжлэх ухааны аргууд. Ертөнцийн хөдөлгөөний тухайн үндсэн хэлбэрт тохирсон аль нэгэн шинжлэх ухаанд хэрэглэгдэх судалгааны арга барил, ажилбар, танин мэдэхүйн зарчим ба шалгуур чадварын нийлбэр цогцыг тусгай шинжлэх ухааны арга гэнэ. Энд механик, физик, хими, биологи зэрэг байгалийн ухаан, нийгэм хүмүүнлэгийн зэрэг бүх л ухааны аргууд багтана. Шинжлэх ухааныг хөгжүүлэхэд онолыг бүтээх индуктив судалгаа (theory-building research (inductive research) ба онолыг сорьж шалгах дедуктив судалгаа (theory-testing (deductive research) хоёр хоюулаа чухал үүрэгтэй. Бодит байдалд тохирохгүй юм бол ямар ч гоё онол байгаад үнэ цэнэгүй, хэрэггүй. Мөн түүнчлэн ач холбогдолтой онолыг бүтээхэд хэрэг болохгүй юм бол асах их өгөгдөхүүн байгаад ч ашиг тусгүй. Онол өгөгдөхүүн хоёрын энэ харилцаа байнга давтагдаж нь мэдэгдэхүүн ба ажил хэргийг сайн тайлбарлах сайн онол гарахад тус болох хөгжил дэвшлийн спираль маягаар явагддаг.

Салбарын судалгааны аргууд. Шинжлэх ухааны аль нэг салбарын эрдэм ухаан буюу эсвэл өөр өөр шинжлэх ухааны уулзварт үүсдэг ухаанд ашиглагддаг арга барилын тогтолцоог салбарын судалгааны арга гэнэ. Суурь шинжлэх ухаан бүхэн өөрийн судлагдахуун, судлах зүйлтэй, судалгааны өвөрмөц аргатай эрдэм ухааны салаа мөчрийн иж бүрдэл байдаг билээ. **Салбар хоорондын судалгааны аргууд.** Эрдэм шинжилгээний салбар ухаануудын уулзварт голлон чиглэсэн хослон нийлж буюу эсвэл сүлэлдэн барилдсан нийлэг арга барилуудын цогц. Энэ нь арга зүйн өөр өөр төвшингийн элементүүд хослон нэгдэх буюу шүтэн барилдсаны үр дүнд үүсдэг аргууд юм. Шинжлэх ухааны судалгааны дизайны хувьд аргаас гадна хувьсагчууд их үүрэгтэй байдаг. Шинжлэх ухаанч философид ашиглаж болох идэвхитэй хувьсагч, төлөв байдлын хувьсагч, категори хувьсагч, учир шалтгааныг нөхцөлдүүлэгч, тогтмол хувьсагч, үргэлжилсэн хувьсагч, хамаарах хувьсагч, дихитом хувьсагч, хөндлөнгийн хувьсагч, үл хамаарах хувьсагч, интервал хэмжигдэхүүн, завсрын хувьсагч зэрэг байна.

Шинжлэх ухааны судалгаа эрдэм шинжилгээний ажилтны сонирхолд үндэслэж, төрийн захиалга, дэмжлэгтэй хийгддэг. Энэ хоёр үндсэн хөдөлгөгч хүчний харьцааг зөв тогтоож, шүтэн барилдуулж байх нь шинжлэх ухааны талаар төрөөс баримтлах бодлогын гол зорилт, улс орны тогтвортой хөгжлийн стратеги байх учиртай. Энэ тухайд академич Т. Ган-Эрдэнэ бичихдээ: Манай улсад эрдэм шинжилгээний ажлын чиглэл заасан баримт бичиг бол “тэргүүлэх чиглэл, цөм технологи” юм. Энэ чухал баримт бичигт “улс нь

судлаачиддаа санал болгодог төсөл (Government-Initiated Project) эсвэл эрдэмтэн судлаачдын зүгээс улсдаа санал болгодог төслийн (Investigator-Initiated Project) хоёр хэлбэр хоюулаа энэ баримт бичигт агуулагдана. Гэхдээ эзлэх хувь хэмжээ нь өөр өөр. Энэ асуудлыг тодорхойлон **хэн эдгээр ажлуудыг сонгон шалгаруулах юм бэ?** гэсэн дараагийн чухал асуудлыг шийдвэрлэдэг. Дүгнэж хэлэхэд, философийн, шинжлэх ухааны ерөнхий болон тусгай эш онол, арга зүй, аргыг ялгамжтай боловч хооронд нь шүтэн барилдуулж хэрэглэх нь танин мэдэхүйн хувьд илүү үр дүнтэй болохыг тайлал зүйн мэдэгдэхүүний билиг харуулна.

Энэ бүхний үндсэнд орчин үеийн мэдээлийн нийгэмд “шинжлэх ухаан үйлдвэрлэлд” гэдэг уриа “шинжлэх ухаан хүмүүний сэтгэлгээнд, мэдлэг, мэдээлэлд” нэвтрэх ёстой гэдэг шаардлагаар солигдож эхэллээ. Байгалийн шинжлэлийн эрдэмтэд ирээдүй рүү алс харж, бидний мэдэхгүй байгаа зүйлийг идэвхитэй хөгжүүлж, боломжгүй бүхнийг төсөөлөн дүрсэлж чаддаг байх ёстой болж байна. Нобелийн шагналт Зөвлөлтийн эрдэмтэн Лев Ландау “магадгүй, хүмүүний суу билгийн агуу их ялалт нь хүн өөрөө төсөөлөн бодож чадахгүй юмаа ойлгож чаддаг болох явдал байж болох юм” гэж хэлсэн нь юм, үзэгдлийн чинад хамгийн түгээмэл зүй тогтлыг ойлгох сэтгэлгээний өндөр түвшинг зааж байна. Ойлгохуй, үнэнийг ухааж, мэдэх энэ өндөр түвшинд хүрэх судалгааны арга зүйн түгээмэл үндсийг философийн тайлал зүй, мэдэгдэхүүний билгийн гүн увдисын бясалгал гаргаж өгөх болно...